

Байгаль орчин ба нийгмийн менежментийн систем

Монгол Улсын Хөгжлийн банкны
Хөрөнгийн удирдлагын компани,
Хас банк ба
Хаан банкинд

зориулан бэлтгэв.

2020 оны 5 сар

Барилга, хот байгуулалтын яамнаас
MON 49430: Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт зориулан
бэлтгэв.

ВАЛЮТЫН ХАНШ

(2019 оны 9 сарын 3)

Валютын нэр	–	Төгрөг (төг)
1.00 төг	=	0.00038 ам.дол.
1.00 ам.дол	=	2,620 төг.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	-	Азийн хөгжлийн банк
АСХХОХ	-	Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр
ГБОМТ	-	Гүйцэтгэгчийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ХЦБ	-	Хорио цээрийн байгууламж
БОНБУ	-	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОМТ	-	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОХТ	-	Байгаль орны хяналтын тайлан
БОХА	-	Байгаль орчны хамгааллын ажилтан
БНХХААБС	-	Бүсийн ногоон, хүртээмжтэй ХАА-н бизнесийн сан
МУЗГ	-	Монгол Улсын Засгийн газар
ГБМ	-	Гомдол барагдуулах механизм
БОТБУ	-	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ
БОАЖЯ	-	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
төг	-	Монгол төгрөг
БХБЯ	-	Барилга, хот байгуулалтын яам
ХХААХҮЯ	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ТХН	-	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТБТТ	-	Төсөлд бэлтгэх техникийн туслалцаа
БОТУ	-	Байгаль орчны түргэвчилсэн төлөвлөгөө
НШТ	-	Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө
ХА	-	Хамгааллын ажилтан
ХБББ	-	Хамгааллын бодлогын баримт бичиг (2009)
ам.дол	-	АНУ-ын доллар

ХЭМЖИХ НЭГЖ

км ²	-	хавтгай дөрвөлжин километр
кг	-	килограм
га	-	гектар
м ³	-	куб метр
мг/л	-	нэг литрт агуулагдах миллиграм
т	-	тонн метр

Тус тайланд "\$" тэмдэгээр АНУ-ын долларыг илэрхийлнэ.

Тус байгаль орчны үнэлгээ ба хяналтын хүрээ нь зээлдэгчийн баримт бичиг. Энд илэрхийлэх үзэл бодол АХБ-ны Захирлуудын зөвлөл, удирдлага, ажилтнуудын үзэл бодлыг төлөөлөхгүй бөгөөд бүрэн дүүрэн боловсруулагдаагүй байж болно. Азийн хөгжлийн банк тус баримт бичигт улс орны аливаа хөтөлбөр, стратеги боловсруулах, төслийг санхүүжүүлэх эсвэл

тодорхой нутаг дэвсгэр, газар нутгийг ямар нэгэн байдлаар тодорхойлох, иш татахдаа аль нэг нутаг дэвсгэр, газар нутгийн хууль эрх зүйн эсвэл бусад статусын талаар ямар нэгэн дүгнэлт хийгээгүй болно.

Агуулга

I.	ТАНИЛЦУУЛГА	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
A.	Оролцогч СЗ-дын туршлага	6
II.	БОНМС-ИЙН ИНСТИТУЦИЙН ОРЧИН	7
A.	Хууль эрх зүйн ба бодлогын орчин	7
B.	БОНМС-ийн гүйцэтгэх үүрэг, хариуцлага	7
C.	Зөвшөөрөгдөх хөрөнгө оруулалтын төслүүд	11
D.	БОНМС-ийг байгуулах, хэрэгжүүлэх бэлтгэл	13
III.	БОНМС-ИЙН ХЭРЭГЖИЛТ	14
IV.	БОНМС-ИЙГ СЗ-ДЫН БИЗНЕСИЙН ЖУРАМД НЭГТГЭХ	24
A.	СЗ-уудын өнөөгийн байгаль орчин, нийгмийн менежментийн хамрах хүрээ	24
B.	БОНМС ба СЗ-дын үйл ажиллагааг нэгтгэх	27
V.	ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
A.	Гомдол барагдуулах механизм (ГБМ)	30
VI.	ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ БА СУРГАЛТ	34
VII.	ТӨСЛИЙН БАТАЛГАА	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
	ХАВСРАЛТ А. АСХХОХ-Т ХОЛБОГДОХ МОНГОЛ УЛСЫН БОНБУ-ИЙН ШААРДЛАГА, ХУУЛИУД	37
	ХАВСРАЛТ В: АХБ-НЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХИЙГ ХОРИГЛОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА	44
	ХАВСРАЛТ С. ТӨСЛИЙН ШИНЖИЛГЭЭ, АНГИЛАЛ ХИЙХ АЖЛЫН ДЭВТЭР	45
	ХАВСРАЛТ D. БОТБУ-НИЙ ТАЙЛАНГИЙН ТОЙМ	58
	ХАВСРАЛТ Е. АЖЛЫН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН ШАЛГАХ ХУУДАС	60
	ХАВСРАЛТ F. БОНМС-ИЙН АЖИЛТНУУДЫН АЖЛЫН ДААЛГАВАР	63
	ХАВСРАЛТ G. ҮР ДҮН 3-Т ХҮРЭХ БА БНХХААБС-ИЙН АЖИЛЛАГАА	65
	Хүснэгт 1. БОНМС-ийг хэрэгжүүлэх институцийн үүрэг	7
	Хүснэгт 2. БОНМС-ийн тайлангийн төлөвлөгөө.....	23
	Хүснэгт 3. БОНМС-ийн сургалтын хөтөлбөр.....	35
	Хүснэгт 4. Монгол Улсын АСХХОХ-т холбогдох хууль	38
	Зураг 1. Байгаль орчны ба нийгмийн менежментийн системийн тайлагнах журам.....	24
	Зураг 2. Гомдол барагдуулах механизм.....	33

I. ТАНИЛЦУУЛГА

1. Санхүүгийн гурван зуучлагч (СЗ) болох Монгол Улсын Хөгжлийн банкны (МУХБ) Хөрөнгийн удирдлагын компани (ХУК), Хас банк, Хаан банк болон тэдний зээлдэгчидэд зориулж Байгаль орчны ба нийгмийн менежментийн системийг (БОНМС) боловсрууллаа. БОНМС нь АСХХОХ-ийн 3-р үр дүнг (доороос үзнэ үү) хэрэгжүүлэхэд удирдамж болно. БОНМС нь СЗ-дын зүгээс АСХХОХ-д нийлүүлж буй хөрөнгийнхөө байгаль орчин ба нийгмийн нөлөөллийг амжилттай удирдах зорилгоор хэрэгжүүлэх дотоод удирдлагын систем юм.

2. АСХХОХ-д оруулж буй хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нь АСХХОХ-өөс үндэслэн байгуулах Бүсийн, ногоон, хүртээмжтэй хөдөө аж ахуйн (агро) бизнесийн хөрөнгө оруулалтын сангаар (БНХХААБС) дамжуулагдах ба энэ санг ХБ-ны ХУК-с томилох хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгж (ТХН) удирдана гэж үзэж байгаа болно. БНХХААБС-аас олгох санхүүжилтийг санхүүгийн гурван зуучлагчдаас зөвшөөрч баталсан зээлдэгчдэд ТХН-ээр дамжуулан зээлдүүлнэ.

3. АСХХОХ нь байгаль орчинд ээлтэй хот суурины хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, хүлэмжийн хий багатай бэлчээрийн менежмент, тогтвортой ХАА-бизнесийн өртгийн сүлжээг ногоон, уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон ХАА-нутаг дэвсгэрийн хөгжлийн тогтолцоонд нэгтгэнэ. АСХХОХ нь одоо байгаа санаачлагууд дээр тулгуурлаж байгаль орчинд ээлтэй, ХАА-н эдийн засгийн төрөлжилт болон бэлчээрт нүүрсхүчлийн давхар исэл (CO₂)-ийн шингээлтийг нэмэгдүүлсэнээр уур амьсгалын өөрчлөлтөд илүүтэй дасан зохицсон мал аж ахуйд түшиглэсэн хүн амын суурьшлын бүс (сум, аймгийн төв) бий болгох бодлогын суурь өөрчлөлтийг дэмжих болно.

4. АСХХОХ нь олон шатлалт зээлийн санхүүжилтийн шугам (ОШСЗШ)-аар санхүүжигдэнэ. ОШСЗШ-ын 1-р шатлалын БОНМС нь баруун гурван аймгийн төв (Увс аймгийн төв Улаангом, Баян-Өлгий аймгийн төв Өлгий, Ховд аймгийн төв Жаргалант) болон хоёр сум дундын төвд (Увс аймгийн Өмнөговь сум, Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум) төвлөрч байна.

5. АСХХОХ-өөс дараах 4 үр дүн [стратегийн зорилт гэж мөн нэрлэж буй] гарах болно:

(i) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, карбон ялгаруулалт бага, хүмүүсийг урин дуудсан аймаг сумын төвүүд болж хөгжинэ.

(ii) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, карбон хуримтлал ихтэй, тогтвортой мал аж ахуй эрхлэх бэлчээрийн менежменттэй болно.

(iii) Карбон бага ялгаруулдаг, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон хүртээмжтэй өртгийн сүлжээг үүсгэж бэхжүүлнэ.

(iv) Байгаль орчинд ээлтэй нутаг дэвсгэрийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах болон чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

6. БОНМС нь СЗ-дын хэрэгжүүлэх үр дүн 3-д анхаарах ба энэ нь дараах арга хэмжээг хамарна: (i) бэлчээрийн тогтвортой менежмент болон хот-хөдөөг холбох болон МАА-н үйлдвэрлэлийн өртгийн сүлжээг дахин бий болгох чиглэлээр ажилладаг малчид, жижиг, дунд ААН (ЖДҮ)-үүдийг санхүүжүүлэх, (ii) бэлчээрийн тогтвортой менежмент болон хот-хөдөөг холбох мөн МАА-н үйлдвэрлэлийн өртгийн сүлжээг төрөлжүүлэх чиглэлээр ажилладаг малчид, дунд болон томхон ААН-үүдийг санхүүжүүлэх, (iii) хөтөлбөрт хамрагдаж

буй санхүүгийн байгууллагуудад зээлийн эрсдлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх зээлийн батлан даалт гаргах, хөтөлбөрийн агробизнесийн өртгийн сүлжээг санхүүжүүлэх схемийн нэг хэсэг болгон үүсгэх барьцаа орлуулагчийг хүлээн зөвшөөрөх боломжийг хөнгөвчлөх, (iv) байгаль орчинд илүү ээлтэй, илүү хүртээмжтэй, өрсөлдөх чадвартай мал аж ахуйн үйлдвэрлэлийн өртгийн сүлжээг бий болгоход чиглэсэн шинэ санаа, сэдлийг арилжааны сүлжээнд оруулахад чиглэсэн бизнесийн урамшуулал болох буцалтгүй тусламж олгох.

7. АСХХОХ-ийн урьдчилсан урьдчилсан өртөгийг 735 сая ам.доллар гэж тооцов. I шатлалын тооцоот өртөг нь 270 сая ам.доллар болж байна. Санхүүгийн зуучлагчийн зээлийн (СЗЗ) бүрэлдэхүүн хэсэгт 45 сая ам.доллар шаардагдах бөгөөд үүний 35 сая ам.долларыг Ногоон уур амьсгалын сангаас (УАНС), 10 сая ам.долларыг Хөгжлийн банк болон арилжааны банкны санхүүжилтээс авах болно. Дээр дурдсанчлан, үр дүн 3-т (стратегийн зорилт) зориулж гаргах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг БНХХААБС-с эхлэн санхүүжүүлэх ба ХБ-ны ХУК хариуцан зохицуулна. БНХХААБС-ийн үйл ажиллагааны талаар Хавсралт G-д үзүүлэв.

A. Оролцогч санхүүгийн зуучлагчдын туршлага

8. ХБ-ны ХУК нь АХБ-ны санхүүжилт бүхий хөгжлийн хөтөлбөрийн санхүүгийн зуучлагчийн хувьд анх удаагаа БОНМС-ийг хэрэгжүүлэх болно. ХУК бол Хөгжлийн хөрөнгө оруулалтын санг бүрдүүлэх, удирдах зорилгоор ХБ-аас шинээр үүсгэсэн байгууллага юм. Одоогийн байдлаар ХУК нь дотооддоо тогтсон БОНМС-гүй, энэ талаарх албан ёсны бодлогогүй, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төслүүдийн нийгмийн болон байгаль орчны магадлан шинжилгээ хийх мэргэшсэн ажилтангүй байна. ХБ-ХУК нь Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл (ОНОСХШТ)-д зориулж хэтдээ Эко-дүүрэг ба төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны санг (ЭДТЧНОСС) байгуулж, удирдахад туслах ба сангаас гарах санхүүжилтийг санхүүгийн зуучлал хэлбэрээр ажиллах арилжааны банкуудаар дамжуулан олгох болно. Гэхдээ ОНОСХШТ-ийн ЭДТЧНОСС-аас ялгаатай нь ХБ-ХУК нь БНХХААБС-г удирдахаас гадна сангаас гаргах хөрөнгийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдад олгох СЗ-ийн үүргийг гүйцэтгэх болно.

9. Хас банк нь өөрийн тогтсон БОНМС-тэй гэж тайлагнасан. Хас банк нь хувийн хэвшлийг дэмжихэд зориулсан АХБ-ны санхүүжилтийн санхүүгийн зуучлагчаар ажиллахдаа БОНМС-ийг хэрэгжүүлсэн. Үүний нэгэн адил Хаан банк нь нийгмийн болон хүрээлэн буй орчны магадлан шинжилгээний системтэй гэж тайлагнасан боловч АХБ-ны санхүүжүүлсэн төслүүдийн хувьд СЗ-аар ажилласан туршлага байхгүй.

10. Иймд БОНМС-ийн талаарх СЗ-дын туршлагын хэр хэмжээ болон чадавхаас шалтгаалан энд танилцуулж буй БОНМС-ийг хамгийн бага туршлага хүчин чадал бүхий санхүүгийн зуучлагч болох ХБ-ХУК-т тохирох хялбаршуулсан алхамуудыг техникийн бус хэллэгээр бэлтгэсэн болно. Түүнчлэн, санхүүгийн гурван зуучлагчидад зориулсан нэг ерөнхий БОНМС байх нь чухал бөгөөд ингэснээр шинээр байгуулагдсан БНХХААБС-гийн гол удирдах байгууллага, менежер нь болох ХБ-ХУК-ийн хувьд түүнийг гүйцэтгэж удирдахад нь хялбар дөхөм байх болно. Хас банк ба Хаан банк нь байгаль орчин, нийгмийн хамгааллын чиглэлээр урьд өмнө нь хуримтлуулсан туршлагатай учраас энд тайлбарлаж буй БОНМС-ийг хялбархан ашиглаж хэрэгжүүлэх болно. Үүнтэй нэг адил нэг чухал зүйл бол АХБ-ны боловсруулсан бие даасан, хялбаршуулсан БОНМС-ийн журам нь цааш цаашдын төслийг хэрэгжүүлэх, хяналт тавихад дэмжлэг үзүүлэх зөвлөхүүдэд (ТХХТЗ) түүнд хяналт тавих, удирдах, шаардлагатай бол асуудлыг засаж залруулахад нь хялбар дөхөм байх болно.

II. БОНМС-ИЙН ИНСТИТУЦИЙН ОРЧИН

A. Хууль эрх зүй ба бодлогын орчин

11. АСХХОХ болон БНХХААБС нь Монгол Улсын болон АХБ-ны бодлого, хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байна. I шатлалд бэлтгэсэн БОТБҮ, БОМТ-тэй уялдуулан АСХХОХ-т холбогдох хууль тогтоомж, бодлогыг Хавсралт А-д үзүүллээ. Эдгээр хуулиуд нь байгаль орчныг хамгаалах, төлөвлөлт, нөлөөллийн үнэлгээ, усны нөөцийн менежмент, агаар, ус, хөрс, шуугиан, хатуу хог хаягдлыг зайлуулах чанарын стандарт, ургамал, амьтан, соёлын нөөцийг хамгаалах удирдамж зэргийг хамарч байгаа болно. Нийгмийн асуудлын хувьд газар ашиглах эрхийн шилжүүлэг, албадан нүүлгэн шилжүүлэлт, үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, ядуу, бага орлоготой, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн эмзэг бүлгийн хүмүүсийн эрх ашгийг хамгаалах чиглэлүүд багтаж байна.

12. Энд тайлбарлаж буй БОНМС нь АХБ-ны Хамгааллын бодлогын баримт бичгийн (АХБ-ХБББ, 2009) шаардлагыг хангасан. АХБ-ХБББ-т (2009) байгаль орчин, уугуул иргэд, албадан нүүлгэн шилжүүлэх гурван үйл ажиллагааны бодлого тусгагдсан. Эдгээр нь хүрээлэн буй орчин, нийгмийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх, аль болох бага байлгах, бууруулахад чиглэдэг. АХБ-ХБББ-ийн (2009) дагуу "Санхүүгийн зуучлалын зээл" (СЗЗ) ангилалд орж буй төслүүд нь Байгаль орчин, нийгмийн удирдлагын системийг боловсруулах шаардлагатай бөгөөд үүнд шалган шинжилгээ, ангилал, үнэлгээ; баримт бичиг бэлтгэх шаардлага ба хянан шалгах журам; байгаль орчны болон нийгмийн чиглэлээр ажиллах ур чадвар, мэргэжилтнүүдийг багтаасан зохион байгуулалтын бүтэц, сургалтын хэрэгцээ шаардлага; хяналт ба тайлагнах гэсэн бүтэцтэй байна.

B. БОНМС-ийг хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг, хариуцлага

13. БОНМС-ийг хэрэгжүүлэх байгууллагуудын үүрэг хариуцлагыг дараах хүснэгт 1-д хураангуйлж харуулав.

Хүснэгт 1. БОНМС-ийг хэрэгжүүлэх байгууллагуудын хүлээх үүрэг

Байгууллага	Үүрэг, хариуцлага
АСХХОХ-ийн Удирдах хороо ба Гүйцэтгэх ажлын хэсэг	• Төслийг улс, аймаг, агентлаг хооронд уялдаа холбоо, дэмжлэгээр шаардагдах хэмжээнд хангах • Гүйцэтгэгч агентлагт дээд түвшний дэмжлэг үзүүлэх • Төсөл хэрэгжүүлэх талаар зөвлөгөө өгөх • Төслийн явцыг хянах
Барилга, хот байгуулалтын яам	• Төслийн гүйцэтгэгч агентлаг (ТГА) • БОНМС-ийг оролцуулан төслийн төлөвлөлт, менежмент, хэрэгжилтийг нийтэд нь хариуцах • Зээлийн гэрээг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэх • ХХААХҮЯ, МУХБ, БОАЖЯ, АХБ-тай уялдаж ажиллах
Монгол Улсын Хөгжлийн банк (ХБ)	• ХБ-ХУК-ийн дэмжлэгтэйгээр БНХХААБС болон СЗ-ыг хэрэгжүүлнэ • ХБ нь БНХХААБС-аар дамжуулан олгох зээлийн талаар СЗ-чдад (ХУК-ийг оролцуулан) удирдамж өгнө
Төслийн удирдах нэгж (ТУН) - УБ:	• Аймаг дахь төслийн нэгжид (АТН) дэмжлэг үзүүлэх
ТУН Дэд зохицуулагч (#3) хамгаалал, магадлан шинжилгээ, худалдан авах ажиллагааны, Санхүүгийн хэлтэс, ХБ дахь ТХН	ТУН болон ХБ-ны байгаль орчин болон нийгмийн хамгааллын томилогдсон ажилтнууд: • БОНМС бий болгож хэрэгжүүлэхэд нь СЗ-дад (ХУК, Хас банк, Хаан банк) дэмжлэг үзүүлэх • Шинэчилсэн БОНМС-ийн төслийг АХБ-д илгээж эцэслэн батлуулах • Төслийн гомдол барагдуулах механизмыг хянаж, эцэслэх • Батлагдахаас нь өмнө хөрөнгө оруулалтын мэдүүлгийн байгаль орчны болон нийгмийн хэсгийг боловсруулж, сайжруулахад нь СЗ-дад дэмжлэг үзүүлэх • Хөгжлийн ангилал тус бүрийн эхний 2 (туршилтын) мэдүүлгийн хувьд хамгааллын асуудлыг шалган шинжилгээ болон ангилал хийсэн баримт бичгийн төслийг АХБ-д илгээж хянан батлуулах • СЗ-дад зориулсан хамгааллын сургалт явуулах • АХБ-д явуулах БОНМС-ийн хэрэгжилтийн явцыг багтаасан Байгаль орчны хяналтын жилийн тайлан (БОХТ) бэлтгэх, үүнд барилгын ажил хийгдэхгүй хүйтний улирлын 6 сард БОНМС-ийн тайлагналд нийцүүлэх. • Хамгааллын бүх заалтуудыг багтаасан зээлийн болон төслийн гэрээ, БОНМС-ийг мөрдөж байгааг хянах. • ТУН-ийн байгаль орчны болон нийгмийн асуудал хариуцсан ажилтнуудад зориулсан ажлын удирдамж нь I шатлалын БОМТ, ЗУГА-д өгөгдсөн болно.

Санхүүгийн зуучлагчид (СЗ) ХУК, Хас банк, Хаан банк	• БНХХААБС-ийн зээлийг дамжуулан олгох байгууллагууд (СЗ-чид) • БОНМС-ийг хэрэгжүүлэгч байгууллагууд • СЗ бүр батлагдсан хөрөнгө оруулалтын бүх төслүүдэд зориулж БОНМС-ийг амжилттай боловсруулж хэрэгжүүлэхийн тулд байгаль орчны асуудлын мэргэшсэн 2 ажилтан, нийгмийн асуудлын мэргэшсэн 2 ажилтнуудыг авч ажиллуулна. • ХУК-ийн дээрх мэргэшсэн ажилтнууд нь БНХХААБС-ийн ТХН-ийн нэг хэсэг байж болно. • СЗ тус бүрийн байгаль орчны болон нийгмийн асуудлын нэг нэг ажилтнууд аймаг дахь төслийн нэгж (АТН) БОНМС-ийг давхар хэрэгжүүлнэ. • БОНМС болон БНХХААБС-г бий болгож, удирдаж, хэрэгжүүлнэ. • БОНМС-ийг СЗ-дын холбогдох бизнесийн дүрэм журамд нэгтгэж оруулна. • Гомдол барагдуулах механизм (ГБМ)-ыг хэрэгжүүлэхэд нь Улаанбаатар дахь ТУН болон АТН-д дэмжлэг үзүүлнэ. • Хүсэлт гаргаж буй хөрөнгө оруулагчдын нийгэм, байгаль орчны хамгааллын талаарх мэргэшил, туршлагад үнэлгээ хийх. • Шалгуурт тэнцсэн хөрөнгө оруулагчдын зүгээс оруулж буй өмчийн хөрөнгө оруулалт тутамд хамгааллын нөхцлийг даган мөрдөж байгааг хянах, тайлагнах. • ТУН-ээс АХБ руу явуулах явцын тайланд нэгтгэх жилийн БОХТ-г байгаль орчин, нийгмийн ажилтнуудаас өгөх мэдээллийг оруулж боловсруулна.
СЗ-ийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд	• БОНМС-ийг хэрэгжүүлэхийн тулд СЗ-ийн санхүүгийн ажилтнууд болон шалгарсан хөрөнгө оруулагчидтай нягт хамтран ажиллана. Хөрөнгө оруулалтын хүсэлтийг БОНМС-ийн хэрэгжилтийн 6 үе шатны дагуу хянах (доор буй III бүлэг) ба хөрөнгө оруулалтын бүх өргөдлүүдийг оруулж бэлтгэсэн БОНМС-ийн мэдээллийн санг ажиллуулна. • ГБМ-ыг хэрэгжүүлэхэд аймгийн төслийн нэгж болон ТУН-д дэмжлэг үзүүлнэ. • Төслийн шийдэл болон хамгааллын асуудлаар сургалт зохион байгуулна. • Шаардлага хангасан хөрөнгө оруулагчдын БОНМС-ийн хэрэгжүүлэлтийг хянаж шалгана. • БОНМС-ийн явцын ээлжит тайланг тогтмол бэлтгэж, БНХХААБС-аас зээл авах шинэ төслүүдийн хамгааллын шаардлагыг хураангуйлан оруулна . • ТУН-д хамгааллын асуудлын жилийн явцын тайланг гаргаж, үүнд БНХХААБС-аас зээл авсан төслүүдийн байгаль орчны хяналтн тайланг оруулна. • АХБ-д хүсэлт гаргах эсвэл жилийн БОХТ-г бэлтгэхэд нь туслах зорилгоор ТУН-ийг шаардлагатай мэдээллээр хангах. • СЗ-дын байгаль орчин ба нийгмийн ажилтнуудын ажлын удирдамжийг Хавсралт F-д үзүүлэв.

СЗ-ийн Санхүүгийн ажилтнууд	- Хөрөнгө оруулалтын хүсэлтийг хүлээн авч шаардлагатай бол хүсэлт гаргагч, ТУН болон бусад байгууллагын хамт БОНМС-ийн хэрэгжилтийн 6 үе шатны дагуу хяналт хийх. - БОНМС-ийн хэрэгжилтийн 6 үе шатны үр дүнг хөрөнгө оруулалт тус бүрээр нарийвчлан баримтжуулж, СЗ тус бүрийн БОНМС-ийн өгөгдлийн санд оруулна - Холбогдох хамгааллын арга хэмжээ зөвшөөрөгдсөн эсэх болон төслийн шийдэлд тусгагдсан ийн арга хэмжээ хэрэгжиж буй эсэхийг хянах зорилгоор шалгарсан хөрөнгө оруулагч, ТУН болон бусад агентлагуудтай холбоо тогтоож ажиллах.
Аймгийн төслийн нэгж: Хамгааллын асуудал хариуцсан баг (СЗ-ийн байгаль орчны ба нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд)	- Нийт БОНМС-ийн хэрэгжүүлэлт хариуцаж буй УБ дахь СЗ-ийн байгаль орчин болон нийгмийн асуудлын ажилтнуудтай уялдаж ажиллах. - БОНМС-ийн шаардлагын дагуу хөрөнгө оруулалтын төсөлд хамааралтай байгаль орчин болон нийгмийн мэдээ, үзүүлэлтүүдийг олж авах. - БОНМС-ийн шаардлагын дагуу хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтэд шаардагдах байгаль орчин, нийгмийн хяналт шинжилгээний явцад нийтэд нь хяналт тавих. - БОНМС-ийн шаардлагын дагуу хяналтын тайланг УБ хот дахь СЗ-дын түншүүдэд ирүүлэх.
Зээлийн өргөдөл гаргагч (БНХХААБС-д өмчийн хөрөнгө оруулалт хийх боломжтой хөрөнгө оруулагч)	- Сонгогдсон СЗ-дтай хамтарч ажиллаж, төслийн шалгуур, ангилал хийх болон төслийн шийдлийг бүрэн гүйцэтгэх. - Хөрөнгө оруулалтын төслийн зураг төслийг үзэх, талбайд очих боломжийг СЗ-чид болон ТУН-д гаргаж өгөх. - Өмчийн хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох байгаль орчны болон нийгмийн асуудлаар заагдсан аливаа нөхцлийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх.
“Эхлэлийн” байгаль орчны хамгааллын зөвлөх (АХБ-ны зээлийн хүрээнд хөтөлбөрөөс гадна техникийн дэмжлэг үзүүлнэ)	- Зээлийн хэрэгжилтийн асуудлаар байнга ажиллах зөвлөхүүдийг сонгож байх хугацаанд БОНМС-ийг үүсгэх ажлыг эхлүүлэхэд нь ТУН, БХБЯ/ГЗБГЗЗГ, ХХААХҮЯ-д дэмжлэг үзүүлэхээр дунд хугацаагаар ажиллах дотоодын зөвлөх. - СЗ-чид (ХУК, Хас банк, Хаан банк) болон ТУН-т БОНМС, ГБМ бий болгоход нь дэмжлэг туслалцаа үзүүлэх. - СЗ тус бүрт зориулан БОНМС-ийн хэрэгжилтийн талаар анхны сургалт явуулах.
Зээлийн хэрэгжилтийн зөвлөх: Байгаль орчны мэргэжилтэн ба нийгмийн асуудлын мэргэжилтэн (АХБ-ны зээлийн хүрээнд хөтөлбөрөөс гадна техникийн дэмжлэг үзүүлнэ)	- БОНМС-ийг бий болгох, хэрэгжүүлэхэд нь СЗ-дад нарийвчилсан заавар, туслалцаа үзүүлэх. - СЗ тус бүрээс сонгогдсон нийгмийн болон хүрээлэн буй орчны хамгааллын ажилтнуудад зориулж БОНМС-ийн хэрэгжилтийн талаар “эхлэлийн” зөвлөхийн явуулж эхэлсэн сургалтыг үргэлжлүүлнэ. - БОНМС-ийн шаардлагын дагуу гэрээт гүйцэтгэгчдийн бэлтгэсэн байгаль орчны хяналтын тайланг хянаж шалгах. - АХБ руу явуулах жилийн БОХТ-г боловсруулахад нь УБ дахь ТУН-д туслах. - Зөвлөхийн гүйцэтгэх ажлын удирдамжийг I шатлалын БОМТ, ЗУГА-д тусгасан болно.

Азийн хөгжлийн банк	• Гүйцэтгэгч болон хэрэгжүүлэгч агентлагуудын зүгээс төслийг удирдаж байгаа талаар болон зээлийн гэрээг цаг тухайд нь биелүүлж буй эсэхэд хяналт тавина. • Зураг төслийн шийдэл болон хяналт шинжилгээний хүрээ, БОМТ, БОНМС, нийгмийн төлөвлөгөө, зээлийн удирдлагын гарын авлагын (ЗУГА) дагуу төслийн нийцэл, зорилтыг хянах. • Шаардлагатай бол шинэчлэгдсэн БОНМС-ийг хянаж, зөвшөөрөх. • СЗ-дын гүйцэтгэсэн төслийн ангиллыг шалгаж, шаардлагатай бол засварлана. • Магадлан шинжилгээний тайланг АХБ-ХБББ-тэй (2009) нийцэж буй эсэхийг шалгаж үзэх. • Төслийн явцыг хянах, мөн хяналт гүйцэтгэх баг илгээнэ. • Хяналт шинжилгээний тайлангуудыг АХБ-ны цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулна.
---------------------	--

АХБ = Азийн хөгжлийн банк, ХУК = Хөрөнгийн удирдлагын компани, БОМТ = байгаль орчны менежментийн төлөвлөгөө, БОНМС = байгаль орчны ба нийгмийн менежментийн систем, БНХХААБС (GIRAF) = Бүсийн, ногоон, хүрээмжтэй ХАА-н бизнесийн сан, ГБМ = гомдол барагдуулах механизм, СЗ = санхүүгийн зуучлагч (ХБ-ХУК, Хас банк, Хаан банк), ЗУГА = Зээлийн удирдлагын гарын авлага, ТУН = ГЗБГЗЗГ/БХБЯ, ХААХҮЯ.

С. Зөвшөөрөгдөх хөрөнгө оруулалтын төслүүд

14. БНХХААБС-д хүлээн авч болохуйц хөрөнгө оруулалтын төслүүдийн цар хүрээ үүнээс үүдэлтэй БОНМС нь АХБ-ны ХБББ (2009) болон Монгол улсын Байгаль орчны үнэлгээ хийх тухай хуулийн тодорхой хязгаарлалтууд, БНХХААБС-ийн холбогдох зорилтууд, АСХХОХ-ийн үр дүн 3-д (стратегийн зорилго) тодорхойлсон төслийн харьцангуй хязгаарлагдмал төрлөөр хязгаарлагдана. Тухайлбал АХБ-ны байгаль орчны ангилал А-д хамаарах төслийг зөвшөөрөхгүй. Хүлээн авч болохуйц төслүүдийн ерөнхий шалгуурыг доор харуулав. Боломжит төслийн хөрөнгө оруулалтын нарийвчилсан шалгуур шинжилгээг БОНМС-ийн хэрэгжилтийн нарийвчилсан алхамуудын хамт III бүлэгт харуулав).

1. АСХХОХ-ийн стратегийн үр дүн 3

15. АСХХОХ-ийн үр дүн 3 нь байгаль орчинд ээлтэй, карбон бага үүсгэдэг, хүртээмжтэй МАА-н үйлдвэрлэлийн өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж МАА-н үйлдвэрлэлийн салбарт түлхэц өгөхөд чиглэнэ. Үр дүн 3 нь: (i) малчид, хөдөө аж ахуйн хоршоологчдод өртгийн сүлжээг бий болгоход шууд оролцох боломжийг олгоно (ii) бэлчээрийн тогтвортой менежментийн чиглэлээр малчдын хоршоо болон МАА-н үйлдвэрлэлийг санхүүжүүлэх зорилгоор БНХХААБС байгуулах, (iii) хот, хөдөөгийн уялдаа холбоог сайжруулах, эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэсэн бэлчээрийн менежментийн чиглэлээр малчид, ХАА-н бизнесүүдэд зээл олгох системийг бүрдүүлнэ.

2. Бүсийн, ногоон, хүртээмжтэй ХАА-н бизнесийн сангаас дэмжлэг авах төслүүд, тэдгээрийн шалгуур үзүүлэлт

16. БНХХААБС нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн өртгийн сүлжээ бий болгох байгаль орчинд ээлтэй, өрсөлдөх чадвартай, эдийн засгийн төрөлжсөн хөрөнгө оруулалтыг тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн менежменттэй үр дүнтэй холбож өгөх санхүүгийн оролцоог дэмжинэ. Доор жагсаасан БНХХААБС-гаар дамжуулан хөрөнгө оруулалт хийх зорилтот төслийн төрлүүдийг I шатлалын хувьд БНХХААБС-д зориулж тодорхойлсон хөрөнгө оруулалтын хоёр чиглэлээр нэгтгэсэн

(Хавсралт А) бөгөөд энэ нь төслийн төрлөөр бус зөвхөн ХБ-ХУК-ийн хүлээх үүргээр ялгагдана. БНХХААБС-гаас санхүүжүүлэх бүх хөрөнгө оруулалтын төслүүдэд малчдын хоршоолол болон тэдэнтэй түншлэлийн гэрээ байгуулсан жижиг, дунд ААН-үүд зайлшгүй хувьцаа эзэмших буюу эсвэл малчид орлогоосоо шууд ашиг хүртэх ёстой. БНХХААБС-д зориулсан хөрөнгө оруулалтын төслийн төрлийг доор харуулав.

- (i) Зорилтот аймаг, сумын төвүүд дэх АСХХОХ-ийн санхүүжилт бүхий агро паркад байрлах мах боловсруулах шинэ үйлдвэр
- (ii) зөвхөн малын тэжээл болон үр авахад зориулсан тариалангийн талбайг усжуулалтын шинэ услалтын систем
- (iii) Агро-үйлдвэрлэл хөгжүүлэх зорилгоор АСХХОХ-ийн агро паркад дараахь МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах; а) мах; б) нэхий хийх (арьс шир боловсруулах биш); ноос; ноолуур; сүүн бүтээгдэхүүн:
 - а) мах, б) нэхий хийх (арьс, шир боловсруулах биш), ноос, ноолуур, сүү, цагаан идээ
- (iv) Хүнсний ногооны үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт нь МАА-н үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтаас тусдаа байна:
 - (а) хүлэмжийн аж ахуй, б) АСХХОХ-ийн агро-паркад малын хаягдал, бохирыг боловсруулах.
- (v) Дээрх бүх хөрөнгө оруулалтын хувьд БНХХААБС нь дараахь чиглэлээр дэмжлэг үзүүлнэ. Үүнд:
 - Шаардлагатай эргэлтийн хөрөнгө
 - Тоног төхөөрөмж худалдан авах
 - Барилга угсралтын ажил
 - ТЭЗҮ/бизнес төлөвлөгөө боловсруулах
 - ТЭЗҮ/бизнес төлөвлөгөө боловсруулахтай холбогдсон судалгаа хийх
 - Инженерийн нарийвчилсан зураг төсөл

17. 3 СЗ нь БНХХААБС-аар дамжуулж зөвхөн дараах шалгууруудыг хангасан хөрөнгө оруулалтын төслийг батална:

- усны нөөцийг үр ашигтай ашиглах;
- бүх хэрэглэгчдийн усны хангамжийг тогтвортой байлгах, хамгаалахад чиглэх
- Малтай харьцах, мах боловсруулах бүх үйл явц нь олон улсын стандартад (НҮБ-ХХААБ 2004, ДЭМБ 2008) нийцсэн байх ёстой.
- Бүх байгууламжийн бохир усыг олон улсын стандартын дагуу цуглуулж, цэвэрлэх ёстой (ОУСК-БОЭМААУ 2007)
- хөрс хамгаалах практикийг хэрэгжүүлэх;
- эрчим хүчний хэмнэлттэй шийдлийг оруулж ашиглах;
- органик бус бордоо зэрэг ХАА-н химийн бодисын хэрэглээг хамгийн бага байлгах
- хортон шавьж устгах бодисыг хэрэглэхээс аль болох зайлсхийж, хортон шавьжтай тэмцэх нэгдмэл арга барилаар орлуулах
- малын хаягдлыг (өтөг бууц) аль болох органик бордоо болгон дахин ашиглах
- ХАА-н уламжлалт арга барил, туршлагыг аль болох ашиглах, цаашид хадгалж үлдээх

- төсөлд өртөж буй олон нийт, бизнес эрхлэгчдийн оролцоотой зөвлөлдөх уулзалтын үр дүнг зураг төсөлд шууд тусгах
- бүх хөрөнгө оруулалтад эмэгтэйчүүд, ядуу хүн ам, мөн үндэстний цөөнхийн шууд оролцоог хангах.

3. АХБ-ны хамгааллын бодлого (ХБББ 2009)

18. БНХХААБС-ийн хөрөнгө оруулалтын төслүүдэд байгаль орчин, нийгмийн хамгааллын дараах шалгуур үзүүлэлтүүд тавигддаг. Хамгааллын шалгуурыг АХБ-ХБББ-т (2009) тодорхойлсон байдаг.

- АХБ-ны хориглосон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны жагсаалтад орсон төслүүдийг (хавсралт В) санхүүжүүлэхгүй.
- БНХХААБС-с олгох төслийн бүх хөрөнгө оруулалт нь Байгаль орчны зориулалтаар В эсвэл С ангилал байж болно. А ангиллын ямар ч хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй.
- БНХХААБС дэх төслийн бүх хөрөнгө оруулалт нь (В эсвэл А ангилалд) албадан нүүлгэн шилжүүлэх юм уу нутгийн уугуул иргэдийг оруулсан бол хамрагдах боломжгүй.
- Төслийн бүрэлдэхүүн хэсэг нь Дархан цаазат газар, Байгалийн цогцолборт газар, Байгалийн нөөц газар зэрэг Үндэсний тусгай хамгаалалттай газар нутаг (ТГХН) дотор байрлах ёсгүй. ТХГН-ийн зах орчмын бүсүүдийг мөн дээрх хязгаарлалтад оруулна.
- Төслийн бүрэлдэхүүн хэсэг нь ховор, нэн ховордсон ан амьтдын амьдрах орчны бүсэд (ХБББ 2009) байрлах ёсгүй.
- Аливаа соёлын биет нөөц, өв, үнэт зүйлд ямар ч байдлаар нөлөөлөх ёсгүй.

D. БОНМС-ийг бий болгож, хэрэгжүүлэх бэлтгэл ажил

19. ХБ-ХУК-аас БНХХААБС-г үүсгэн бий болгож ашиглахаас өмнө байгууллагуудын хувьд дараахь гурван шаардлагыг хангасан байх ёстой:

1. Санхүүгийн зуучлагч тус бүр БОНМС-ийг хүлээн зөвшөөрч хамтын гэрээ хийсэн байх
2. БНХХААБС-аас хөрөнгө оруулалтын төслүүдэд олгох журмыг санхүүгийн зуучлагчид хамтдаа боловсруулж, тохиролцсон байх.
3. Санхүүгийн зуучлагч тус бүр БОНМС-ийг байгууллагуудын хамтарсан журамд хэрхэн нэгтгэж оруулсан тухай төсөл хэрэгжүүлэх зөвлөх болон АХБ-ны суурин төлөөлөгчийн газарт танилцуулсан байх.

1. Байгууллагуудын зүгээс БОНМС-ийг хүлээн зөвшөөрөх

20. СЗ-чид болох Хас банк, ХАА-н банк, ХБ-ХУК нь БОНМС-ийг байгууллагуудынхаа бизнесийн журамд албан ёсоор оруулж нэгтгэсэн болохыг тус тусдаа баримтжуулж өгөх ёстой. Байгууллагын удирдлагын зүгээс БОНМС-ийг хүлээн зөвшөөрч баталсан бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд бэлэн байгаа тухай мэдэгдсэн албан ёсны тушаал, зааврыг байгууллага бүр АХБ, БХБЯ-нд өгөх ёстой.

21. БОНМС-ийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх үйл явц нь ХБ-ХУК-аас БНХХААБС-г байгуулж, ажиллуулж эхлэхээс 3-аас доошгүй сарын өмнө 3 СЗ тус бүр дээр хийгдсэн байх ёстой. Ялангуяа СЗ тус бүрийн албан ёсны тушаал, заавар нь дараах заалтуудыг багтаасан байна. Үүнд: (i) БОНМС-ийг байгууллагын харьяаллын бүх хүрээнд БНХХААБС-т холбогдох хамгааллын бодлого гэж албан ёсоор хүлээн зөвшөөрөх, (ii) БОНМС-ийн дүрэм журам нь тухайн банкны хөрөнгө оруулалтын үнэлгээ, батлах журмын нэг хэсэг болсон тухайгаа Хас банк ба ХАА-н банкууд БНХХААБС-ийн хөрөнгийг удирдах ХБ-ХУК-ийн санхүүгийн ажилтнуудад мэдэгдэнэ, (iii) 3 СЗ-дын хувьд, холбогдох байгууллагууд БОНБҮ-ийг хэрэгжүүлэх явцад хийгдэх бүх арга хэмжээ, шийдвэрүүдэд зориулагдсан удирдлага, хяналтын арга хэмжээнүүдийг нэр, албан тушаалаар нь тодорхойлох, (iv) 3 СЗ-дын хувьд, шаардлага хангасан хөрөнгө оруулагчдын зүгээс байгаль орчны болон нийгмийн талаар тавигдсан нөхцөл шаардлагуудыг зөрчсөн тохиолдолд байгууллага бүр тэдэнд ижил шийтгэл ноогдуулж, зээлийн бусад нөхцлийг зөрчсөнтэй адил шийдвэрлэх болно гэдгийг батлах, (v) Хас банк ба ХАА-н банкны хувьд, эдгээр банкууд ба ХБ-ХУК-ийн хооронд болон мөн 3 СЗ ба ТУН, АСХХОХ-ийн зээл хэрэгжүүлэх зөвлөхүүдийн (ТХХТЗБ) хоорондын ажлын харилцаа холбоог баталгаажуулна, (vi) БОНМС-ийн баримт бичгийн монгол хувилбарыг санхүүгийн зуучлагч тус бүрт тарааж өгсөн байх (*СЗ-дын санхүүгийн ажилтнуудад зориулсан БОНМС-ийн Хавсралт С-ийн монгол хувилбарыг төслийн талбайд болон өдөр тутмын үүргийн нэг хэсэг болгож хэвлэж ашиглах зааврын хамт*), (vii) Бүх СЗ нь БОНМС-ийн сургалтын төлөвлөгөөнд хамрагдах үүрэг хүлээх ба шаардлагатай тохиолдолд СЗ-ын сургалтын албаны ажилтнуудыг сургалтанд зайлшгүй хамруулна.

2. БНХХААБС-ийн санхүүжилтийн журмын гэрээ

22. БНХХААБС-г 3 СЗ-ийн нэг болох ХБ-ХУК боловсруулж, удирдана. СЗ нь бүгд ижил БОНМС-ийг ашиглах хэдий ч өөрсдийн холбогдох байгууллагуудын зүгээс зөвшөөрөгдсөн төслийн хөрөнгө оруулалтийг БНХХААБС-аас санхүүжилт олгох нийтлэг ил тод журмын талаар нарийвчлан тодруулж, тохиролцох ёстой. Эдгээр журам нь БОНМС-ээс тусдаа байх хэдий ч чухал үүрэгтэй бөгөөд БНХХААБС-гийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө ТУН-ээс үүнийг шийдэж цэгцэлсэн байх ёстой.

3. БОНМС-ийн талаарх СЗ-дын танилцуулга

23. СЗ-дын дотоод журамд БОНМС хэрхэн үр дүнтэй нэвтэрч байгааг харуулах зорилгоор зуучлагч тус бүр байгаль орчин, нийгмийн асуудлын амжилтан болон төслийн хэрэгжилтийн зөвлөх мэргэжилтнүүдэд танилцуулга хийх ёстой. Танилцуулгыг СЗ-дын байгаль орчны болон нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд, мөн БНХХААБС-д ирүүлж буй хөрөнгө оруулалтын бүх хүсэлтийг нягтлан үзэх үүрэг бүхий санхүүгийн үндсэн ажилтнууд гүйцэтгэх ёстой. Танилцуулгад БОНМС-ийн иж бүрэн журам, зээлийг хянан шалгах журамд БОНМС хэрхэн нийцэж байгаа, байгаль орчин, нийгмийн ажилтнуудын үүргийг хамруулсан СЗ-ийн зохион байгуулалтын схем, БОНМС-ийг нэвтрүүлэхэд зориулсан жилийн төсвийн хуваарилалтыг тус тус багтаана. БОНМС-ийг амжилттай хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавьдаг ажилтнуудын зүгээс тавигдах асуулт, тодруулгад хариулах замаар нарийвчилсан тохируулга хийх боломж олгодог тул ингэж танилцуулга хийх нь БОНМС-ийг нэвтрүүлэх ажлын нэг чухал алхам болох ёстой.

III. БОНМС-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

24. БНХХААБС-д хүсэлт гаргаж буй хөрөнгө оруулалтын төсөл бүрийн хувьд БОНМС-ийг дараахь 6 шатлалаар хэрэгжүүлнэ. А) Шинжилгээ хийх В) Байгаль орчин, нийгмийн ашиг

тусын тулд санал болгож буй төслийн шийдлийг боловсронгуй болгох; С) Төслийн ангилал; D) Нөлөөллийн үнэлгээ; E) Хамгааллын хэрэгжилт; F) Хяналт шинжилгээ, тайлагнах. А-аас D хүртэлх шат нь хөрөнгө оруулалтын төсөл батлагдах эсэхийг тодорхойлохын тулд зайлшгүй хийгддэг магадлан шинжилгээний нэг хэсэг юм. Батлагдсан төслийг хэрэгжүүлэх явцад E-F алхамууд хийгддэг. Эдгээр бүх шат дарааллыг СЗ-ийн бие даасан санхүүгийн ажилтнууд, байгаль орчны болон нийгмийн ажилтнууд гүйцэтгэх бөгөөд шаардлага хангасан хөрөнгө оруулагчид, ТУН-ийн байгаль орчин, нийгмийн ажилтнууд, зээлийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөх багийн (ТХХТЗБ) байгаль орчны болон нийгмийн зөвлөхүүдтэй хамтран ажиллана. Мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах, олон нийттэй зөвлөлдөх, төслийн сөрөг нөлөөлөлд өртөх хүмүүсийн оролцоог хангах нь Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон АХБ-ны Хамгааллын бодлогын баримт бичиг (2009)-ээр тавигдах үндсэн шаардлагууд болно. Мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах болон олон нийттэй зөвлөлдөх үйл ажиллагаа D-E алхамуудад орсон байгаа. COVID-19 г.м. олон улсын эсвэл дотоодын эрүүл мэндийн асуудал гарвал барилгын ажил эхлэхээс өмнө аль болох эрт эсвэл боломж бүрдсэн хугацаанд нь зөвлөлдөх ажиллагааг оновчтой гүйцэтгэх магадлашгүй байдлын төлөвлөгөө шаардлагатай болно.

АЛХАМ А: БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ЗОРИЛГООР САНАЛ БОЛГОЖ БУЙ ТӨСЛИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Шалгуур 1 – Үндэсний болон олон улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх

- A.1. Өмчийн хөрөнгө оруулалтын хүсэлтэд Монгол Улсын хуульд заагдсан ямар нэг зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа орсон эсэх (Хавсралт А).
- A.2. Өмчийн хөрөнгө оруулалтын хүсэлтэд АХБ-наас хориглосон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны жагсаалтад багтсан ямар нэг үйл ажиллагаа байгаа эсэх (Хавсралт В).
- A.3. Хүсэлт гаргагчийн хувьд байгаль орчин, газартай холбоотой, эсвэл бусад асуудлаар Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн гэсэн одоо байгаа эсвэл хүлээгдэж буй нэхэмжлэл байгаа эсэх.
- A.4. Хэрэв дээрх асуулгын аль нэгэнд "тийм" гэж хариулсан бол хүсэлтийг буцаах, эсвэл хүсэлтийг тавигдаж буй шаардлагыг хангаж чадахуйц болтол боловсруулсны дараа дахин хүсэлт гаргахыг зөвлөх.
- A.5. Дээрх бүх асуулгад "үгүй" гэж хариулсан бол дараагийн алхамуудыг үргэлжлүүлнэ.

Шалгуур 2 – Байгаль орчны ба нийгмийн асуудлын шинжилгээ

- A.6. Зээл хүсэгчтэй уулзаж, газар дээр нь очиж үзэх.
- A.7. Хавсралт С-ийн 1-4 дэх иж бүрэн асуулгыг бөглөх (байгаль орчин, газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх, газар ашиглах эрх шилжүүлэх, үндэстний цөөнх).
- A.8. А алхамыг бүхэлд нь дуусгасны дараа В алхам руу шилжинэ.
- A.9. А алхамыг давсан эсэхээс үл хамаарч бүх хүсэлтүүдийг баримтжуулж тэмдэглэнэ. Зээлийн хүсэлт тус бүрд хийсэн шинжилгээний үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг ТУН

ба АХБ руу явуулах БОНМС-ийн тайланд тусгана.

А.10. А үе шатны зардлыг СЗ төлнө. (гол төлөв СЗ-ийн санхүүгийн ажилтны зарцуулсан ажлын цаг г.м).

АЛХАМ В: НОГООН, КАРБОН БАГАТАЙ, ТОГТВОРТОЙ ХАА-Н БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ

В.1. Хавсралт С дэх асуулгын 5-р хуудсанд БНХХААБС-ийн зүгээс дэмжихээр зорьж буй байгаль орчинд ээлтэй ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төрлийг тодорхойлсон болно. Зээлийн хүсэлт гаргахад тохирох хүмүүсийг тодруулах. Асуулгын 5-р хуудсанд заагдсан шаардлагад нийцсэн тогтвортой, цаг уурын өөрчлөлтөд тохирсон ухаалаг шийдэлд хүрэхийн тулд санал болгож буй төслийн загварыг боловсронгуй болгох. Тайлбар: Хүсэлт гаргагч нь СЗ-дын байгаль орчин, нийгмийн ажилтнууд, ТУН-ын байгаль орчны ажилтнууд, ТХХТЗБ-ийн байгаль орчин, нийгмийн зөвлөхүүдтэй шууд зөвлөлдсөний үндсэн дээр энэхүү алхамыг гүйцэтгэнэ.

В.2. Хүсэлт гаргагч нь (мөн ТУН) В.1 алхамыг хангалттай хэмжээнд гүйцэтгэсэн эсэхийг тодруулна.

В.3. Төслийн хөрөнгө оруулалтад тавигдах нөхцөл шаардлагад байгаль орчинд ээлтэй, карбон бага ялгаруулдаг ХАА-н үйлдвэрлэлийн шийдэл, арга хэмжээг тусгах (D алхамыг үзнэ үү).

В.4. ТУН-д явуулах А.9 тайланд В алхамын хүрээнд авсан бүх мэдээлэл, үр дүнг оруулна.

В.5. В алхамыг бүрэн хийж дуустал С алхам руу орж болохгүй.

АЛХАМ С: БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙГ АНГИЛАХ

С.1. АХБ ба Монгол Улсын шалгуурын дагуу байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллийн түвшин ба төслийн "нөлөөллийн ангилал"-ийг тодорхойлоход А алхам дахь мэдээллийг ашиглана.

Ангилал 1 – Байгаль орчин (АХБ-ны шалгуур үзүүлэлт ба шаардлагууд)

С.2. АХБ нь төслүүдийн хувьд А, В, С гэсэн нөлөөллийн гурван ангиллыг баримталдаг. Хавсралт С-д буй асуулгын 1-р хуудас дахь тодорхойлолтыг үзнэ үү. Асуулгын 1-р хуудаст буй хүснэгтийн эцсийн баганыг бөглөнө. Зээлийн хүсэлттэй холбоотой болзошгүй нөлөөлөл бүрийг А, В, С ангилалд хуваарилах.

С.3. Эдгээр үр дүнг ашиглан хүснэгтийн дор буй нөлөөллийн ангиллын хураангуйг дугуйлж тэмдэглэнэ. Энэхүү дүгнэлтэд хүргэсэн шалтгааныг тодорхой зааж өгнө.

С.4. Хүрээлэн буй орчны хувьд В юм уу С зэрэглэлтэй байх үед л санал болгож буй төслийг хүлээн авах боломжтой. Байгаль орчинд үзүүлэх нөлөө маш бага эсвэл нөлөөгүй байх тул хамгааллын магадлан шинжилгээ нь харьцангуй хурдан бөгөөд хямдхан байдлаар гүйцэтгэгддэг С ангиллын төслүүдийг түлхүү авч үздэг. Хэрэв байгаль орчны хувьд эцсийн ангилал нь А бол төслийн хүсэлтийг буцаах, эсвэл уг төсөл нь байгаль орчны хувьд В буюу С ангилалд багтаж байхаар сайтар нягталж боловсруулсаны дараа

дахин хүсэлт гаргахыг зөвлөнө.

Ангилал 2 – Байгаль орчин (Монгол Улсын шаардлага, шалгуур үзүүлэлт)

С.5 Монгол улсын хуулийн дагуу хийх эхний алхам бол БОАЖЯ-д хандаж төслийн байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх (шалгуур шинжилгээ) хүсэлт гаргана. Энэ хүсэлт нь дараах үндсэн мэдээллийг агуулсан байна: i) төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт, ii) төслийн нарийвчилсан төлөвлөлтийн тайлбар, зураг төслийн хамт, iii) төслийн техник эдийн засгийн үндэслэл. Дэлгэрэнгүй тодорхойлолтуудыг Хавсралт А-аас үзнэ үү. БОАЖЯ-ны ерөнхий үнэлгээнээс дараах боломжит шийдлүүд гарна:

- (i) Төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) эсвэл БОМТ-гүйгээр хэрэгжүүлэхийг зөвшөөрөх.
- (ii) БОМТ-нд заасан тусгай нөхцөлүүдийг хэрэгжүүлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авснаар төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-гүйгээр хэрэгжүүлэхийг зөвшөөрөх.
- (iii) Төслийг хэрэгжүүлэхэд бүтэн БОННУ шаардлагатай.
- (iv) Холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, хүрээлэн буй орчинд тоног төхөөрөмж, технологийн ихээхэн сөрөг нөлөөтэй, газар зохион байгуулалт, менежментийн төсөл байхгүй гэсэн шалтгаанаар төсөл хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх.

25. БНХХААБС нь эдгээр ангиллын аль ч төсөлтэй хамтран ажиллах боломжтой. Байгаль орчинд үзүүлэх нөлөө бага байдаг тул зөвхөн БОМТ хийх шаардлагатай гэж ангилагдсан төслүүдийг түлхүү авч үзнэ.

Ангилал 3 – Сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт

С.5. АХБ нь төслүүдэд нөлөөллийн А, В, С гэсэн гурван ангиллыг баримталдаг. Шалгуур шинжилгээ ба ангиллын стандартыг Хавсралт С-ийн 2, 3-р хүснэгтэд¹ тусгасан болно. Эдгээр ажлын хуудсыг санал болгож буй төсөл А, В, С ангиллын алинд хамаарч буйг тодорхойлох зорилгоор ашиглана.

С.6. А ба В ангилалд багтсан болон урьд нь эзэмшиж байсан газар эсвэл одоо байгаа байгууламжаас албадан нүүлгэн шилжүүлэх асуудалтай ямар нэг байдлаар холбогдсон бол төслийн бүх хүсэлтийг хүлээж авахаас татгалзана. Үүнд газар нутгийг албадан эзэмших, ашиглалтыг нь албадан хязгаарласнаас үүдэлтэй биет юм уу эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт, алдагдалд хүргэх төслүүд багтана. Хэрэв албадан нүүлгэн шилжүүлэлтийн хувьд А эсвэл В ангиллд орсон бол хүсэлт гаргагч нь уг төслийг С ангилалд багтах болтол нь өөрчлөн нягт нямбай, нотолгоотой боловсруулсны дараа дахин хүсэлт гаргаж болно.

Ангилал 4 – Уугуул иргэд (үндэстний цөөнх)

С.7. АХБ нь төслүүдэд нөлөөллийн А, В, С гэсэн гурван ангиллыг баримталдаг. Шинжилгээ ба ангиллын стандартыг Хавсралт С-ийн 4-р хүснэгтэд тусгасан болно². Энэхүү ажлын хуудсыг санал болгож буй төсөл А, В, С ангиллын алинд хамаарч буйг

¹ Мөн <http://www.adb.org/site/safeguards/safeguard-categories> хуудсыг үзнэ үү.

² Мөн <http://www.adb.org/site/safeguards/safeguard-categories> хуудсыг үзнэ үү.

тодорхойлох зорилгоор ашиглана.

С.8. А ба В ангилалд багтсан төслүүдийн хүсэлтийг хүлээж авахаас татгалзана. Түүнчилэн уугуул ард иргэд эсвэл угсаатны цөөнхийн бүлгийн хүмүүсийг урьд өмнө хийж байсан үйл ажил, одоо байгаа байр сууцнаас салгах аливаа асуудлыг багтаасан төслүүдээс татгалзах ёстой. Хэрэв уугуул иргэдийн хувьд А эсвэл В ангилалд багтсан бол хүсэлт гаргагч нь төслийг С ангилалд багтах болтол нь нягт нямбай, нотолгоотой өөрчлөн боловсруулсны дараа дахин хүсэлт гаргаж болно.

Ангилал 5 – Газар ашиглах эрхийн асуудал

С.9. Одоо байгаа буюу санал болгож буй газар ашиглах эрхийн гэрээтэй холбоотой аливаа төслийг ТМО, СЗ-ийн санхүү, нийгмийн ажилтнууд хянан үзэх ёстой. Хавсралт С-ийн 4-р хуудсыг ашиглан ямар нэгэн асуудал, зохицуулах шаардлагатай маргаан байгаа эсэхийг шалгана. Хэрэв "Тийм" гэсэн хариу гарвал төслийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзана, эсвэл хүсэлт гаргагч нь баримт бичгийг бүхэлд нь хууль ёсны дагуу шийдвэрлэсний дараа хүсэлтээ дахин гаргах боломжтой.

С.10. Газар ашиглалтын хувьд Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны (БАНХ) аймаг, сумын түвшин дэх бэлчээр ашиглагчдын бүлгүүдийн (БАБ) боловсруулж буй бэлчээр ашиглагчдын гэрээг (БАГ) авч үзэх шаардлагатай. БАНХ нь БХБЯ, ГЗБГЗЗГ-ийн хамт ТУН-ыг бүрдүүлдэг ХХААХҮЯ-ны харьяа байгууллага юм. Төслийн нөлөөлөлд өртсөн нутагт БАГ байгаа эсэх болон ямар байдалтай байгааг тодорхой болгохын тулд СЗ-дийн санхүү, нийгмийн ажилтнууд ТУН-той зөвлөлдөх ёстой. Хүсэлт гаргагч нь СЗ-дын хамт газар ашиглах эрхийн талаар Газрын тухай хуулийг судалж үзэх (2002), төслийн бүс дэх одоо байгаа эсвэл цаашид бий болох БАГ-ний талаар БАНХ-той зөвлөлдөх ёстой. Газрын тухай хууль (2002) нь хувь хүн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглахтай холбоотой асуудлыг зохицуулдаг. Мөн энэ хуулиар улсын тусгай хэрэгцээний газар эзэмших эрхийн талаарх өргөн зарчмуудыг тогтоосон болно.

26. С алхамд гарах бүх зардлыг СЗ төлөх ёстой. Зардал нь ерөнхийдөө санхүү, байгаль орчин, нийгмийн ажилтнууд хүсэлт гаргагчидтай уулзаж, харилцах, газар дээр нь очиж үзэхэд зарцуулсан ажлын цагийг багтаана.

Санал болгож буй ангиллыг Засгийн газар, АХБ зөвшөөрч батлах

С.11. Алхам С-д цуглуулсан бүх мэдээлэл, үр дүнг А.9-ийн бүрэлдэхүүнд алхам В-ийн талаар ТУН-д явуулах явцын тайланд оруулна.

С.12. ХАА-н үйлдвэрлэлийн төслийн төрөл тус бүрийн эхний 2 хүсэлтийн хувьд доор дурдсан жишээгээр ажиллана:

(i) Услалтын систем, тэжээлийн аж ахуй,

(ii) Агро паркийн барилга байгууламжууд: (хорио цээрийн бүс, мал эмнэлгийн болон лабораторийн үйлчилгээ, мах боловсруулах үйлдвэр, малын гаралтай бүтээгдэхүүн хадгалах газар, малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх төв, агро паркаас гарах бохир усыг цуглуулах, цэвэрлэх байгууламж г.м).

(iii) Агро парк руу очих ахуйн үйлчилгээ (инженер)-ийн шугам хоолой.

(iv) Агро парк руу очих зам

Шалгуур шинжилгээний баримт бичиг, санал болгож буй эрсдлийн ангиллыг ТУН, АХБ-д хянуулж, батлуулахаар ирүүлнэ. ТУН нь баримт бичгийг АХБ руу явуулна.

С.13. Засгийн газар, АХБ-ны зүгээс төслийн хүсэлтийн талаархи саналаа илэрхийлж, хүсэлтийг бүрэн батлах хүртэл хүсэлтийг цааш нь үргэлжлүүлж болохгүй.

С.14. С алхамыг бүрэн хийж дуустал D алхам руу орж болохгүй.

АЛХАМ D: НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, ТӨСЛИЙГ БАТЛАХ

Байгаль орчны үнэлгээ

D.1. Хэрэв төсөл нь байгаль орчны хувьд АХБ-ны В ангилалд хамаарах бол АХБ-ХБББ-т (2009) заагдсан шаардлагын дагуу Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) багтаасан Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ (БОТБҮ) хийнэ. Хэрэв төсөл С ангилалд хамаарах бол хялбаршуулсан БОМТ ба ГБМ хийж болно.

D.2. Хэрэв төсөл нь байгаль орчны хувьд АХБ-ны С ангилалд хамаарах бол дараахь зүйлсийг хийх шаардлагатай: (i) Монгол улсын шаардлагын дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээг бэлтгэх (БОМТ, С алхамыг үзнэ үү), (ii) болзошгүй нөлөөллийг тодорхойлох, тэдгээрийг бууруулах арга хэмжээг авах чиглэлээр байгаль орчны шалгалтын товч жагсаалтыг бэлтгэх. Шалгалтын жишиг шалгах хуудсыг Хавсралт Е-д үзүүлэв.

D.3. Хүсэлт гаргагчдад дараах чиглэлээр зөвлөгөө өгнө. Үүнд:

(i) Монгол Улсын ЗГ-аас заагдсан шаардлагын дагуу гүйцэтгэгч нь БОМТ-г боловсруулах ажлыг гүйцэтгэгч хариуцах ба гарсан зардлыг төлөх үүрэгтэй, (ii) Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг энэ ажлыг хийх эрх бүхий байгууллага хийж гүйцэтгэнэ, (iii) Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хянан шалгуулахаар СЗ болон ТУН-д ирүүлнэ, (iv) БОТБҮ-нд Хавсралт D-д үзүүлсэн материалуудыг багтаасан байх ба мөн англи хэл дээрх хувийг бэлтгэнэ, (v) ТУН нь БОТБҮ-ний эхний хувилбарыг хянаж батлуулахаар АХБ руу илгээнэ, (vi) Монгол Улсын шаардлагын дагуу хийгдэх БОМТ болон БОННУ нь зөвхөн монгол хэл дээр байх ба БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газарт явуулна.

D.4. БОТБҮ хийх ажил нь цаг хугацаа шаарддаг, зардал ихтэй байдаг тул дээр дурдсанчилан С ангилалд багтах, зөвхөн БОМТ хийгддэг төслүүдийг түлхүү авч үздэг.

D.5. Хэрэв В ангилалд хамрагдаж буй төслийн хүсэлт гаргагч нь дараачийн шат руу орохыг хүсвэл СЗ болон ТУН-ийн байгаль орчин, нийгмийн ажилтнуудтай уулзаж, дараахь зүйлийг тодруулж, тохиролцоно. Үүнд: (i) үнэлгээний үйл явц, (ii) байгаль орчинд хамгийн ээлтэй, нүүрстөрөгч бага ялгаруулах агро-үйлдвэрлэлийн хөгжилд хүрэх зорилгоор төслийн шийдлийг өөрчлөн сайжруулах. СЗ нь уулзалт зохион байгуулах газрыг бэлдэх (шаардлагатай бол) ба төлбөрийг хариуцна. Уулзалтад ирэх буцах тээврийн зардлыг талууд өөрсдөө хариуцна.

D.6. Хүсэлт гаргагч нь БОТБҮ (БОМТ-ний хамт) ба/эсвэл дотоодын БОМТ, БОННУ хийхэд бэлтгэнэ. Баримт бичиг бүрдүүлэх, хээрийн судалгаа, суурь үзүүлэлтүүдийн

хяналт шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлэг зэрэгт гарах бүх зардлыг хүсэлт гаргагч хариуцна.

Нийгмийн үнэлгээ ба нөлөөллийг бууруулах араг хэмжээний бэлтгэл

D.7. (i) Хэрэв санал болгож буй төсөл нь газар ашиглалтын эрхэд нөлөөлж болзошгүй бол хүсэлт гаргагч нь Газрын тухай хууль (2002) болон холбогдох дүрэм журамд заасны дагуу нөлөөлөлд өртсөн газрын өнгөрсөн, одоо болон ирээдүйн ашиглалтын эрхийг тайлбарласан баримт бичгүүдийг бэлтгэх ёстой. СЗ нь эдгээр баримт бичгүүд болон АСХХОХ-ийн I шатлалд зориулан бэлтгэсэн Нүүлгэн шилжүүлэлтийн хүрээ (НШХ)-нд тогтоосон заалтуудыг хянаж үзэхэд нь хүсэлт гаргагчдад тусална. Хүсэлт гаргагч нь гэрээний хувийг СЗ-д хадгалуулсан хуулбараар ТУН-д өгнө. (ii) Хэрэв санал болгож буй төслийн газар нь ашиглагчийн өөрчлөлттэй холбоотой бол хүсэлт гаргагч нь шийдвэрлэгдэхээр хүлээгдэж буй маргаан байхгүй гэдгийг баталгаажуулахын тулд холбогдох нотлох баримтыг ТУН-д ирүүлэх ёстой. Ийм магадлан шалгалтыг Монгол Улсын Газрын тухай хуулийн (2002) дагуу гүйцэтгэх болно.

D.8. Төслийг Нийгмийн хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө (НХҮАТ ба ЖҮАТ), түүнчлэн АСХХОХ-ийн ЗУГА-д багтсан НШХ-ний дагуу хэрэгжүүлэх ёстой. Хүсэлт гаргагч нь төслийн үйл ажиллагаатай холбоотой НХҮАТ ба ЖҮАТ-нд буй шаардлагатай бүх арга хэмжээг хэрэгжүүлж, гарсан үр дүнгийн талаар ТУН-д мэдээлж байгаа эсэхийг СЗ хянана.

D.9. НХҮАТ ба ЖҮАТ-ний холбогдох бүх шаардлагыг (арга хэмжээг) БНХХААБС-д оруулахаар төлөвлөж буй төслийн хөрөнгө оруулалтын гэрээний нийгмийн нөхцлүүдэд тусгах.

Мэдээллийг олон нийтэд ил тод байлгах, олон нийттэй зөвлөлдөх ба олон нийтийн оролцоог хангах

D.10. Нөлөөллийн ангиллаас үл хамааран бүх төслүүдийн хувьд хүсэлт гаргагч нь санал болгож буй төслийн талаараа төслийн нөлөөлөлд өртсөн орон нутагт нийтэд мэдээлсэн байна.

D.11. Хэрэв хариулж нь “Үгүй” бол, хүсэлт гаргагчид дараах зүйлсийг хийх шаардлагатай байгааг мэдээлнэ. Үүнд:

- Төслийн байршил, үйл ажиллагаа, болзошгүй нөлөөлөл, хүсэлт гаргагчтай холбоо барих хаяг, төслийн СЗ болон ТУН-ийн байгаль орчин, нийгмийн ажилтнуудтай холбоо барих хаяг зэрэг үндсэн мэдээллийг түгээх.
- Олон нийтэд биеэр болон бичгээр санал сэтгэгдлээ гаргахад хангалттай хугацаа өгөхийн тулд дээрх мэдээллийг 10-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлэх.
- Аймаг, сумын төвд самбар, зурагт хуудас өлгөх, цахим хуудсанд байршуулах зэргээр төслийн талбайн ойролцоох орон нутгийн иргэд үзэж, харж болох материал, мэдээллийн хэрэгслийг ашиглах.
- Мэдээлэл өгөх хугацааны төгсгөлд хүлээн авсан олон нийтийн саналыг нэгтгэж цэгцлэх (СЗ, ТУН, хүсэлт гаргагч гаргагч),
- Санал сэтгэгдлүүдийг БОМТ, БОННУ, НХҮАТ ба ЖҮАТ-тэй нийцүүлэн шийдвэрлэх.

D.12. Хүсэлт гаргагч нь мэдээлэл түгээх материалын зардлыг хариуцна.

D.13. Байгаль орчин, сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт, уугуул иргэдийн хувьд С ангилалд хамаарах төслүүдийн хувьд дээр дурдсан арга хэмжээнүүд хангалттай байна.

D.14. Байгаль орчны хувьд В ангилалд багтдаг төслүүдийн тэргүүн туршлагагын дагуу хүсэлт гаргагч нь мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэж, олон нийттэй утга учиртай зөвлөлдөж хэлэлцсэн байх ёстой (АХБ-ХБББ-ийн дагуу, 2009). Мэдээлэл өгөх хүрээ, цар хүрээг тохируулж өгөхийг өргөдөл гаргагчид даалгана уу. Төслийн мөн чанар, нөлөөллийг тусгах зорилгоор мэдээллийн нээлттэй байдал, олон нийтийн зөвшилцлийн цар хүрээ, хэмжээг тохируулах, мөн ТУН-ийн болон БОТБҮ хийдэг байгууллагын байгаль орчин, нийгмийн ажилтнуудтай хамтарч ажиллах талаар хүсэлт гаргагчид зааварчилга өгнө. БОТБҮ-г бэлтгэж буй БОНБҮ хийх байгууллага нь мэдээллийн нээлттэй байдал, олон нийттэй зөвлөлдөх ажлыг удирдан зохион байгуулна. Холбогдох НХҮАТ ба ЖҮАТ-ний талаархи мэдээлэл түгээх, олон нийтийн утга учиртай хэлэлцүүлгийг хүсэлт гаргагч хариуцна. Хүсэлт гаргагч нь хүлээн авсан аливаа саналыг шийдвэрлэх зардлыг төлнө.

D.15. Хүсэлт гаргагч нь: (i) БОТБҮ-ний төслийг ТУН-ийн цахим хуудсанд байршуулахаар ТУН-д ирүүлнэ, (ii) БОТБҮ-ний төслийг (эсвэл наанадаж монгол хэл дээрх хураангуйг) орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр эсвэл аймаг, сумын төвийн олон нийтийн самбар дээр тавьж мэдээлсэн байна³.

Засгийн газар болон АХБ-наас баримт бичгийг баталгаажуулах

D.16. А.9-ийн хүрээнд авсан бүх мэдээлэл, үр дүнг алхам С ба алхам В-ийн талаар ТУН-д явуулах явцын тайланд оруулах.

D.17. Байгаль орчны В ангилалд багтсан бүх төслийн хувьд хүсэлт гаргагчид БОТБҮ-ний эцсийн хувилбарыг ТУН, АХБ-д батлуулахаар ирүүлэх ба ТУН нь уг баримт бичгийг АХБ-д өгөх болно. Засгийн газар, АХБ-ны зүгээс БОТБҮ-ний талаар саналаа илэрхийлж, бүрэн батлах хүртэл хүсэлтийг цааш нь үргэлжлүүлж болохгүй.

D.18. Хүсэлт гаргахтай холбоотой бусад баримт бичиг, зөвшөөрлийн хуулбарыг авч, хянана. Тухайлбал:

- ТУН зураг төслийн эцсийн хувилбарыг зөвшөөрөх
- БОАЖЯ-ны зөвшөөрөл,
- АХБ-ны зөвшөөрөл.

D.19. D алхамыг бүрэн хийж дуустал E алхам руу орж болохгүй.

АЛХАМ Е: ХАМГААЛЛЫН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

E.1. Хүсэлт гаргагчтай санал болгож буй төслийн хөрөнгө оруулалтын гэрээ хийхдээ Байгаль орчны үнэлгээнд буй нөлөөллийг бууруулах, хянах, тайлагнах мөн хэрвээ холбогдолтой бол НХҮАТ ба ЖҮАТ-ийн чиглэлээр хүсэлт гаргагчийн хэрэгжүүлэх ёстой

³ БОТБҮ-г англи хэлээр бэлтгэж, АХБ-нд явуулна. БОТБҮ-г монгол хэлээр бэлтгэгдсэн дотоодын байгаль орчны үнэлгээний баримт бичигт үндэслэн бэлтгэнэ.

бүхий л арга хэмжээг жагсаасан Хамгааллын баталгааны бичгийг (ХББ) бэлтгэнэ⁴. Энэ үе шатанд хүсэлт гаргагч нь "шаардлага хангасан төслийн хөрөнгө оруулагч" болох бөгөөд, БННХАС-аас санхүүжилтийн дэмжлэг авах боломжтой болно.

Е.2. Шаардлага хангасан төслийн хөрөнгө оруулагч нь ХББ-д заасан арга хэмжээний хэрэгжилтийг багтаасан төслийг эхлүүлнэ. Шаардлага хангасан хөрөнгө оруулагч нь эдгээр зардлыг төлөх үүрэгтэй.

Е.3. Байгаль орчны хувьд В ангилалд багтсан төслүүдийн хувьд хэрэв шаардлага хангасан хөрөнгө оруулагчид нь гэрээт гүйцэтгэгчдийг ажиллуулах бол: (i) БОМТ, ГБМ, ХББ-ийг тендерийн баримт бичигт тусгасан байх, (ii) гэрээт гүйцэтгэгч нь гэрээг хүлээн авах нөхцөлийн дагуу БОМТ, ГБМ, ХББ-ийг биелүүлэхээр тохиролцсон байх ба тэдгээрийн зардлыг тендерийн саналд оруулах ёстой⁵. Тендерийн баримт бичигт заасны дагуу гүйцэтгэгч(ид) нь барилгын тодорхой ажлуудыг гүйцэтгэхдээ хэрэгжүүлбэл зохих БОМТ-ийн холбогдох шаардлагуудыг гүйцэтгэгчийн БОМТ-д (ГБОМТ) тусгаж оруулах ёстой.

Е.4. Төслийн хэрэгжилтийн бүхий л үе шатанд ТУН-ийн байгаль орчны болон нийгмийн ажилтнуудад гомдол барагдуулах механизмыг (ГБМ) хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ (V бүлгийг үзнэ үү).

Е.5. Байгаль орчинд сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй аливаа нэг төслийн шийдлийг өөрчлөлтийг магадлан шалгаж, үнэлгээ хийх ба хэрэв шаардлагатай бол байгаль орчны нэмэлт хяналт шинжилгээ эсвэл нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулна.

АЛХАМ F: ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ БА ТАЙЛАГНАХ

F.1. Шаардлага хангасан хөрөнгө оруулагч нь Хамгааллын баталгааны бичигт тусгасан арга хэмжээг хэрэгжүүлж байгаа эсэхийг хянана.

F.2. СЗ нь төслийн хөрөнгө оруулалтын хүсэлт ба батлагдсан төсөл тус бүрт А-аас F хүртэлх алхамуудын үр дүнг бүртгэх системийг боловсруулж, мэдээллийг хадгална. Энэ нь энгийн мэдээллийн сан байх ёстой (т: эксел хүснэгтэнд хийсэн).

F.3. БОТБУ шаардлагатай төслүүдийн хувьд БОМТ-нд орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөг тусгасан байх бөгөөд үүнийг шаардлага хангасан төслийн хөрөнгө оруулагч хэрэгжүүлэх ёстой. Үр дүнг БОМТ-д заасан давтамжийн дагуу СЗ-д мэдээлэх ёстой.

F.4. ТУН нь төслийн НХҮАТ ба ЖҮАТ-ний хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Хэрэгжилтийн зөвлөхүүд нь (ТХХТЗ) хяналт шалгалт, тайлагнах механизмыг боловсруулахад нь ТУН-д тусална.

F.5. Дараах агентлагууд доод тал нь төслийн эхний 2 жилийн хугацаанд хагас жил тутамд уулзаж зөвлөлдөх ёстой бөгөөд 4 жилээс цааши хугацаанд жилд нэг удаа уулзалт хийнэ:

⁴ Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний жагсаалтыг АСХХОХ-ийн I шатлалын 3 Аймгийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд оруулсан байгаа. Нийгмийн хамгааллын арга хэмжээний жагсаалтыг алхам D-д оруулав.

⁵ Гүйцэтгэгч эдгээр нөхцөлд гарах зардлыг тендерийн баримт бичигт тусгасан эсэхийг The bidding documents will show if the contractor has included costs for these conditions. A construction supervision company will monitor contractor performance.

- Хамгааллын баталгааны бичигт тусгасан төслийн хөрөнгө оруулалтын гэрээний нөхцлийн явцыг хянах зорилгоор СЗ ба шаардлага хангасан төслийн хөрөнгө оруулагч нар,
- БНХХААБС-аас дэмжлэг үзүүлж буй бүх төслүүдийн хамгааллын хэрэгжилт болон ажлын явцад олж авсан сургамжуудыг СЗ, ТУН болон БОАЖЯ-ны ХБОБНУГ хянаж үзнэ.

F.6. СЗ нь байгаль орчны хяналтын тайланг жил тутамд ТУН-д гаргаж өгөх бөгөөд үүнд СЗ-ийн БОНМС, ГБМ, хамгааллын асуудлаар гарсан ахицыг төсөл тус бүрээр, мөн хамгааллын сургалтын тайланг багтаана. Тайланг ирүүлэх хугацаа: ТУН-ээс БОХТ-г АХБ руу явуулахаас 30 хоногийн өмнө.

F.7. ТУН нь АХБ-д жилийн БОХТ-г явуулахдаа СЗ-аас БОНМС-ийг хэрэгжүүлж буй ажлын явцыг нарийвчлан оруулна. Тайланг ирүүлэх хугацааг 8 сарын 15 эсвэл 2 сарын 15-ны аль нэгээр тогтооно (ө.х. СЗ ТУН-д тайлангаа явуулснаас хойш 30 хоногийн дотор).

F.8. Тайлагнах журмыг хүснэгт 2 болон зураг 1-д үзүүлэв.

F.9. СЗ нь ТУН-д явуулах тайлангийн зардлыг өөрөө хариуцна. ТУН нь АХБ-д явуулах БОХТ-ийнхаа зардлыг өөрөө хариуцна.


F.10. **Торгууль.** Шаардлага хангасан төслийн хөрөнгө оруулагчийн зүгээс төслийн хөрөнгө оруулалтын нөхцөлд заасан байгаль орчин, нийгмийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд торгууль оногдуулна. Тухайлбал: өмчийн хөрөнгө оруулалтын эрхийг хаах, эргэн төлөлтийг түргэвчлүүлэх эсвэл Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу болон СЗ-ийн зохистой гэж үзсэн бусад арга хэмжээг авна.

Хүснэгт 2. БОНМС-ийн тайлангийн төлөвлөгөө

Тайлан	Хугацаа	Хэн хариуцах
Байгаль орчны чиглэлээр В ангилалд багтах төслийн хувьд БОМТ-ний хэрэгжилт, хяналт шинжилгээний дүнгийн тайлан	Төслийн БОМТ-д заасны дагуу	Шаардлага хангасан төслийн хөрөнгө оруулагч СЗ-д ирүүлнэ
СЗ байгаль орчны хяналтын жилийн тайлангаа ТУН-д явуулах, түүнд БОНМС, НХУАТ, ЖУАТ-ний явцыг тусгах	ТУН АХБ-д БОХТ-аа явуулахаас наад зах нь 30 хоногийн өмнө, баталгаажуулах шаардлагатай). Эхний хагас жилийг 7/31-ээр Сүүлийн хагас жилийг 1/37-ээр	СЗ-аас ТУН-д ирүүлнэ
ТУН жилийн БОХТ-аа АХБ-д явуулах	Зааж өгөх: 8 сарын 15 эсвэл 2 сарын 15	ТУН-ээс АХБ-д ирүүлнэ. АХБ хяналт хийж цахим хуудсандаа байршуулна

АХБ = Азийн хөгжлийн банк, СЗ = Санхүүгийн зуучлагч (ХБ-ХУК, Хас банк, Хаан банк), БОМТ = байгаль орчны менежментийн төлөвлөгөө, БОНМС = байгаль орчны ба нийгмийн менежментийн систем, ТУН = БХБЯ эсвэл ГЗБГЗЗГ, мөн ХХААХҮЯ дах төслийн удирдах нэгж, НХУАТ = нийгмийн хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ЖУАТ = жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө.

Зураг 1. Байгаль орчны ба нийгмийн менежментийн системийн тайлагнах шат дараалал



IV. БОНМС-ИЙГ СЗ-ИЙН БИЗНЕСИЙН ЖУРАМД НЭГТГЭХ

А. СЗ-дын байгаль орчин, нийгмийн менежментийн өнөөгийн хамрах хүрээ

27. Санхүүгийн зуучлагчдын байгаль орчин, нийгмийн менежментийн (БОНМС) чиглэлээр хийж буй өнөөгийн үйл ажиллагааны хүрээг доор тоймлон нэгтгэлээ. СЗ-ийн БОНМС-ийн хамрах хүрээний талаарх мэдээлллийг 3 СЗ-тай гурвууланттай нь ганцаарчиж хийсэн уулзалт, ирүүлсэн зарим нэмэлт мэдээлэл (т: ХБ-ХУК), СЗ-ийн цахим хуудас (т: Хаан банк), БОНМС-ийн сүүлийн үеийн мэдээллээс (т: Хас банк) олж авсан болно.

1. ХБ-ХУК

28. ХУК нь Монгол Улсын Хөгжлийн Банкнаас сангийн менежерийн үүрэг гүйцэтгүүлэх үндсэн зорилгоор шинээр үүсгэсэн байгууллага. Иймд ХУК нь СЗ-дын сул хөгжсөн БОНМС-ийг хэрэгжүүлэх ба СЗ-чид нь ЖДҮ-дэд зээл олгох чиглэлээр мөн хуримтлуулсан туршлага багатай. ХУК нь БОНМС-ийн талаар албан ёсоор боловсруулж, бичгээр хэвлэн гаргасан бодлогогүй, нийгмийн болон байгаль орчны хамгааллын мэргэшсэн ажилтангүй байна.

29. ХБ-ХУК нь байгууллагынхаа БОНМС-ийн зорилгыг “*Ди Би Эм ассет менежмент ҮЦК*” ХХК-ийн Хөрөнгө оруулалтын бодлого”-доо дараахь байдлаар тодорхойлсон байна:

....4.9. Хариуцлагатай хөрөнгө оруулалт:

“Хөрөнгө оруулалт нь үр ашигтай байхын зээгцээ байгаль орчинд ноцтой сөрөг нөлөөгүй, нийгмийн хариуцлагатай, тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн байх ёстой. Бид:

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцээгүй,*
- Байгаль орчинд ноцтой сөрөг нөлөөлдөг,*
- Архи, тамхи, зэвсэг үйлдвэрлэх, мөрийтэй тоглоом, цэргийн ажиллагаатай холобоотой төслүүдэд хөрөнгө оруулахгүй”.*

30. Өнөөдрийг хүртэл МУХБ-ХУК нь боломжит хөрөнгө оруулагч/зээлдэгчдийн төсөл нь БОАЖЯ-наас заасан үндэсний БОҮ-ний шаардлагыг хангаж байгаа гэдэгт бүрэн найдаж байна. Шаардлага хангахын тулд хөрөнгө оруулагч/зээлдэгч нь БОНБУ хийх эрх бүхий ААН-ээр гэрээлж гүйцэтгүүлэх ёстой. Хөрөнгө оруулагч/зээлдэгч нь зээл албан ёсоор батлагдаж төсөл эхлэхээс өмнө уг төслийн аливаа нөхцлийг тайлбарласан БОАЖЯ-аас олгодог байгаль орчны үнэлгээний ерөнхий дүгнэлтийг гаргуулсан байх ёстой.

а. Магадлан шинжилгээний өнөөгийн үйл явц⁶

31. Төслийн хөрөнгө оруулалтын хүсэлтэд ХУК-иас хийх байгаль орчин, нийгмийн магадлан шинжилгээний үйл явцыг дараах байдлаар нэгтгэлээ: (i) хөрөнгө оруулагч нь БОАЖЯ, БОНБУ-ээр тавигддаг шаардлагын дагуу бүрэн хэмжээний магадлан шинжилгээ хийсэн гэрчилгээг багтаасан өргөдлийг бүрдүүлнэ, (ii) ХУК-ийн хориглосон хөрөнгө оруулалтын төслүүдийг хүлээн авахаас татгалзана, (iii) төслийг хүлээж авахаас татгалзаагүй тохиолдолд санхүүгийн эрсдлийн үнэлгээтэй зэрэгцүүлэн БОАЖЯ-ны үнэлгээний үр дүнг хянана, (iv) ХУК төслийн хөрөнгө оруулалтыг зөвшөөрсөн тохиолдолд хөрөнгө оруулагч нь БОАЖЯ-аас заасан аливаа шаардлагуудыг цаашдын нөлөөллийн хяналт шинжилгээний хамт хэрэгжүүлсэн байх ёстой.

2. Хаан банк

32. Хаан банк нь байгууллагын нийгмийн хариуцлагын бодлогод (НХБ) тусгагдсан байгаль орчны болон нийгмийн бодлогоор илэрхийлэгддэг дотоодын БОНМС-тэй гэж мэдээлсэн. Тус банк байгаль орчин, нийгмийн бодлогоо (БОНМС) 2009 онд боловсруулсан бөгөөд байнга боловсруулж сайжруулсаар 2019 онд хамгийн сүүлийн шинэчлэлийг хийсэн байна.

33. Хаан банкны тэмдэглэснээр банкнаас тусгайлан томилогдсон ажилтнууд зээлийн хүсэлтэд Монгол Улсын шаардлагын дагуу мөн төслийн санхүүжилтээс хамаарч олон улсын шаардлагын дагуу (ЖАЙКА, АХБ, ДБ, ЕСБХБ) байгаль орчны болон нийгмийн магадлан шинжилгээ хийдэг байна. Тус банкны БОНМС нь ЕСБХБ-аас тавьдаг хамгааллын шаардлагыг хангадаг, түүнчилэн урьд өмнө АХБ-ны зээлийн төсөл дээр хамтран ажиллаж байсан тул мөн АХБ-ны аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа гэж мэдэгдсэн.

34. Тус банк төслийн санхүүгийн эрсдэлд магадлан шинжилгээ хийхийн зэрэгцээ өөрийн байгаль орчны түргэвчилсэн үнэлгээг (БОТҮ) ашиглаж төслийг “улаан”, “шар”, “ногоон” гэж тодорхойлдог. “Улаан” гэж тодорхойлогдсон төслүүд нь нийгмийн болон хүрээлэн буй

⁶ ХУК-тай хийсэн уулзалт болон уулзалтын дараа тэднээс гаргасан өгсний мэдээллээр тодорхойлсон.

орчны үнэлгээг хамгийн их шаарддаг буюу хүлээж авах боломжгүй байдаг бол "ногоон" төслүүд нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн хувьд гэмгүй гэж тооцогддог. Ерөнхийдөө 100 сая төгрөгөөс доош өртөгтэй төслүүд БОНМС-д хамрагдахгүй.

а. Магадлан шинжилгээний өнөөгийн үйл явц⁷

35. Хаан банкны зүгээс зээлийн хүсэлтэд хийдэг байгаль орчин, нийгмийн магадлан шинжилгээг дараах байдлаар нэгтгэв: (i) хүсэлтийг эрсдэлийн удирдлагын хэлтэс хүлээж авна, (ii) санал болгож буй төслийг ХУК-аас хориглосон төслийн жагсаалтын дагуу шуурхай үнэлэх, (ii) хэрэв хориглосон биш төсөл > 100,000,000 төгрөгийн өртөг бүхий бол: (a) банкны өөрийн түргэвчилсэн БОТҮ-г байгаль орчны ажилтан гүйцэтгэнэ, (b) санхүүгийн эрсдлийн үнэлгээ - хэрэв санал болгож буй төсөл < 100,000,000 төгрөгийн өртөг бүхий бол өргөдөлд (b) цаашид байгаль орчны болон нийгмийн магадлан шинжилгээ шаардлагагүй, шууд санхүүгийн эрсдлийн үнэлгээг хийнэ, (iii) хэрэв (a) бол байгаль орчны мэргэжилтнүүд газар дээр нь очиж шалгахдаа "улаан", "шар", "ногоон" гэсэн ангиллыг тодорхойлохын тулд БОТҮ-ний шалгах хуудас ашиглана, (iv) ихэрэв санал болгож буй төсөл нь "улаан" юм уу "шар" өнгөтэй бол зээл санал болгож буй компани нь БОАЖЯ-ны байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний шаардлагын дагуу байгаль орчин, нийгмийн үнэлгээг хийх, эсвэл ЖАЙКА, АХБ, ЕСБХБ зэрэг олон улсын хандивлагч байгууллагуудын шаардлагын дагуу байгаль орчны ажилтантай нягт хамтран ажиллах шаардлагатай, (v) Хэрэв зээл санхүүгийн хувьд боломжтой бол БОАЖЯ эсвэл олон улсын хандивлагч байгууллагаас тогтоосон бүх хамгаалалтын шаардлагыг БОНҮ эрх бүхий компаниар хийлгэх нөхцөлтэйгээр зээлийг зөвшөөрнө.

3. Хас банк⁸

36. Хас банк зээлийн хүсэлтийг хянахдаа ашигладаг дотоодын БОНМС-ийг 2002 онд боловсруулж 2014 онд шинэчилсэн. БОНМС-ийг хэрэгжүүлэх үүрэг бүхий хамгааллын ажилтнууд (ХА) нь тус банкны эко-банкны хэлтэст харъяалагддаг. Хамгааллын ажилтнуудын туршлага нь БОНХС-тэй хамт хөгжиж ирсэн. Тус газар нь 2016 оны 10-р сард Уур амьсгалын ногоон сан (УАНС)-аар⁹ магадлан итгэмжлэгдсэн бөгөөд энэ нь тус банк санхүүгийн менежмент сайтай, санхүүжиж буй төсөл, хөтөлбөрүүдээ байгаль орчин ба нийгмийн сөрөг нөлөөллөөс найдвартай хамгаалах чадвартай болохыг харуулж байна. Банкнаас олгосон зээл, түүний дотор АХБ-аас санхүүжсэн зээлийг зээлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах ажлыг хангах зорилготой үндэсний болон олон улсын бүх (т: АХБ-ХБББ 2009) шаардлагыг дагаж мөрдөж байгааг баталгаажуулахын тулд БОНМС-ийг ашигладаг. Банкны БОНМС нь байгууллагын нийгмийн хариуцлагын бодлогын нэг хэсэг юм.

37. Хас банк нь Хаан банкны нэг адил байгаль орчныг хамгаалахад чиглэсэн төсөл, уур амьсгалын өөрчлөлт, бохирдлыг бууруулах зэрэг нийгмийн "ногоон" ойлголтыг сурталчлах төслүүдийг улам илүү санхүүжүүлж байна. Одоогийн байдлаар Хас банк өөрийн БОНМС-

⁷ Хаан банктай хийсэн уулзалт болон тус банкны вэб хуудаснаас авсан БНХ-ийн бодлогын ерөнхий танилцуулгад үндэслэн тодорхойлсон. Уулзалтын дараа тус банкнаас нэмэлт баримт бичиг хүлээн аваагүй.

⁸ БОНМС-ийн тайлбар танилцуулгыг ОНОСХШТ төсөлд зориулан бэлтгэсэн тайлбар танилцуулга болон банкны ажилтнуудтай хийсэн уулзалтаас авсан болно.

⁹ УАНС нь 2017 он хүртэл Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ийн Гүйцэтгэлийн стандартуудыг дунд хугацаанд мөрдөх хамгааллын стандартаараа хүлээн авсан бөгөөд дараах холбоосоор орж үзэж болно: <http://www.gcfreadinessprogramme.org/sites/default/files/Environmental%20and%20Social%20Safeguards%20at%20the%20Green%20Climate%20Fund.pdf>

ийг (i) Карбон ялгаруулалтыг бууруулах чиглэлээр¹⁰ микро, жижиг, дунд ААН (БЖДҮ)-дэд олгох бизнесийн зээлийн хөтөлбөр, (ii) Сэргээгдэх эрчим хүч – нарны эрчим хүчний хөтөлбөр¹¹ гэсэн хоёр төсөлд хэрэглэж байна.

а. Магадлан шинжилгээний өнөөгийн үйл явц

38. Хас банкны зээлийн зөвшөөрлийн явцыг дараах байдлаар нэгтгэв: (i) зээлийн хүсэлтийг хүлээн авна, (ii) зээлийн хүсэлт гаргагчийн төрлийг тодорхойлно, (iii) банкны зэрэглэлийн систем болон үнэлгээний загварчлалын дагуу төслийн үнэлгээ хийх, (iv) дотооддоо урьдчилан зөвшөөрөл, (v) санхүүгийн магадлан шинжилгээ, хөрөнгө оруулалтын тайлан; (vi) эрсдлийн үнэлгээ, (v) зээлийн зөвшөөрөл. Байгаль орчин ба нийгмийн асуудлын магадлан шинжилгээ нь (iii) алхамаас эхэлнэ.

В. БОНМС-ийг СЗ-дын үйл ажиллагаанд нэгтгэх

39. Байгаль орчны багтай хийсэн уулзалтууд дээр Санхүүгийн зуучлагчид нь үйл ажиллагаандаа БОНМС-ийг нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд саад учруулах бодлого, арга барил байхгүй бөгөөд БНХХААБС-ийн БОНМС-ийн шаардлагыг бүрэн дагаж мөрдөх болно гэдгийг тодорхойлсон. Түүнчилэн одоо ажиллаж байгаа болон шинэ байгаль орчин ба нийгмийн хамгааллын ажилтнууд БНХХААБС-ийн БОНХАЖЯ-ыг хэрэгжүүлж, дэмжих чиглэлээр ажиллах болно гэдгийг СЗ хэлсэн болно.

1. Ялгаатай талууд ба өмчлөл

40. Санхүүгийн гурван зуучлагчийн зээл/хөрөнгө оруулалтыг хянах үйл явц нь дараахь нийтлэг элементүүдтэй байна: (i) зээл/хөрөнгө оруулалтын хүсэлтийг хүлээн авах, (ii) санал болгож буй зээл/хөрөнгө оруулалтын санхүүгийн эрсдэл ба ашгийн түвшинг үнэлэх, (iii) хүсэлтийг хүлээн авах, эсвэл хүлээж авахаас татгалзах. Гэхдээ санхүүгийн сонголтын шалгуур зэрэг зарим нарийн заалтууд (т: санхүүгийн сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлт) нь СЗ-дын дунд маш тод ялгаатай байгааг тэмдэглэх нь зүйтэй.

41. Түүнчилэн дээр 31, 35, 38-р хэсэгт дурдсанчилан, СЗ-дын мэдээлсэн "БОНМС" нь хэмжээ далайц, агуулга, горимын хувьд болон бүртгэгдсэн БОНМС-ийн бодит туршлагын хувьд маш тод ялгаатай байна. Мөн БОНМС нь банкуудын дунд өмчлөлийн шинжтэй байна. Тиймээс энд энгийн, техникийн бус хэллэгээр тайлбарлаж буй БОНМС-ийн давуу тал нь бие дааж, эчнээ байдлаар үүсгэсэн энэхүү системийг БОНМС хамгийн бага хөгжсөн (үндсэндээ байхгүй) ХУК-ийн зүгээс хялбархан хүлээж авч хэрэгжүүлж чадахад оршино. Харин Хас банк, Хаан банк нь одоо байгаа хамгааллын үйл ажиллагаандаа БОНМС-ийг илүү хялбар дөхөм нэгтгэх авах боломжтой. Гэхдээ бүх санхүүгийн зуучлагчид нь тэдний БОНМС-ийн чадавхиас үл хамааран төсөл хэрэгжүүлэх зөвлөхийн (ТХХТЗ) дэмжлэгийг авах мөн энд танилцуулсан БОНМС-ийг байгууллагадаа зохих журмын дагуу нэвтрүүлж, хэрэгжилтийг хангах шаардлагатай.

2. БОНМС-ийг нэгтгэх бэлтгэл ажил

42. Параграф 19-т заасны дагуу БОНМС-ийг ХУК-д нэвтрүүлэхдээ дараахь үндсэн алхамуудыг хэрэгжүүлнэ:

¹⁰ БОНМС-ийг дараах холбоосоор орж үзэж болно: <https://www.xacbank.mn/en/558/about-xacbank/social-responsibility/eco-bank/gcf-news/esms>

¹¹ БОНМС-ийг дараах холбоосоор орж үзэж болно: <https://www.xacbank.mn/en/565/about-xacbank/social-responsibility/eco-bank/gcf-news/esms-on-renewable-energy-program-solar>

1. Байгууллагуудын хамтарсан албан ёсны гэрээ, БОНУС-ийг нэвтрүүлэх талаар албан ёсны хамтарсан гэрээтэй болох ба СЗ бүр зөвшөөрсөн байх.
2. ХУК-ийн хөрөнгө оруулалтын төслүүдэд БНХХААБС-аас санхүүжилт авах журмыг боловсруулж, СЗ-чид хамтран хянаж, бичгээр албан ёсны гэрээ байгуулах.
3. СЗ тус бүр БОНМС-ийг байгууллагуудын хамтарсан журамд хэрхэн нэгтгэснийг АХБ болон төсөл хэрэгжүүлэх зөвлөхөд (ТХХТЗ) танилцуулах.

а. Байгууллага хүлээн зөвшөөрч, нэвтрүүлэх

43. СЗ-дын бизнесийн журамд БОНМС-ийг нэгтгэхийн тулд БНХХААБС байгуулахаас болон төслийн санхүүжилтийн зээлийг авахаас өмнө 3 сараас багагүй хугацааны өмнө санхүүгийн зуучлагч байгууллага тус бүрийн захирлын албан ёсны удирдамжийг гаргана. Энэ үе шатанд СЗ-ийн БОНМС-ийг ТУН ба АХБ-аас хянаж, батална (доор үзнэ үү). СЗ бүрийн Захирлын удирдамж нь дараах дараахь заалтыг агуулна:

- i. Удирдамжид гарын үсэг зурсан өдрөөс эхлэн БОНМС-ийг төсөл хэрэгжих нутаг орон дахь СЗ-ийн бодлого гэж албан ёсоор хүлээн зөвшөөрөх.
- ii. БНХХААБС-тай хамтран ажиллахаар томилогдсон санхүүгийн ажилтнуудад СЗ-ийн БОНМС-ийн алхамууд нь өмчийн хөрөнгө оруулалтын үнэлгээ, батлах журмын нэг хэсэг болох тухай зааварчилгаа өгөх.
- iii. БОНМС-ийг хэрэгжүүлэх явцад үе шатуудад авч хэрэгжүүлсэн удирдлагын болон хянан шалгах арга хэмжээ, шийдвэрийг холбогдох нэр, албан тушаалаар нь тодорхойлох.
- iv. Хэрэв шаардлага хангасан хөрөнгө оруулагчид байгаль орчин, нийгмийн чиглэлээр тавигдсан нөхцөл шаардлагыг зөрчвөл СЗ нь зээлийн бусад нөхцлийг зөрчихөд оноодогтой ижил торгууль оногдуулна.
- v. СЗ ба ТУН, тэдгээрийн зээлийн хэрэгжилтийн зөвлөхүүдийн хоорондох ажлын харилцааг баталгаажуулах.
- vi. Монгол хэл дээрх БОНМС-ийн баримт бичгүүдийг СЗ-дад түгээн тараахийг үүрэг болгох.
- vii. Санхүүгийн ажилтнуудад БОНМС-ийн ажлын маягтыг (БОНМС - Хавсралт С) хувиан хэвлэж төслийн талбайд ажиллах үедээ хэрэглэж үүргийнхээ дагуу тэмдэглэж бөглөхийг зааварлах.
- viii. Шаардлагын дагуу СЗ-ийн ажилтнуудыг сургалтанд хамруулах замаар БОНМС-ийн сургалтын төлөвлөгөөнд хамрагдах үүрэг хүлээх.

б. БНХХААБС-ийн журмыг ойлгож, хүлээн зөвшөөрөх

44. БНХХААБС-г ТХХТЗ, АХБ-ны зохих тусламжтайгаар ХБ-ХУК боловсруулж, удирдна. 3 СЗ нь энд тайлбарласан нэг л БОНМС-ийг хүлээн авч, нэвтрүүлэн ашиглах болно. ХУК нь өөрөө санхүүгийн зуучлагч болох тул энэ 3 байгууллага өөрсдийн харьяа байгууллагуудын төслийн хөрөнгө оруулалтад БНХХААБС-аас санхүүжилт олгох нийтлэг журмын талаар ижил ойлголттой, энэ талаар зөвшилцсөн байх нь чухал. БОНМС-ээс гадуур байгаа эдгээр

процедур мөн чухал бөгөөд БНХХААБС үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө ТУН-д мэдэгдсэн байх ёстой.

45. СЗ-дын дунд нэгдсэн ойлголцол, зөвшилцөл бий болгохын тулд ХУК нь БНХХААБС-аас санхүүжилт олгох журмын талаар СЗ-дын хамтарсан уулзалт дээр танилцуулах ёстой. БНХХААБС-аас санхүүжилт олгох журам нь БОНМС-ийг нэвтрүүлэхэд нөлөөлж болзошгүй тул СЗ-дыг БОНМС-ийг бүрэн нэвтрүүлэхээс өмнө энэ уулзалтыг ХУК зохион байгуулах ёстой. Уулзалтад ТХХТЗ ба АХБ оролцох ёстой.

с. Нэгдсэн БОНМС-үүдийг батлах

46. СЗ байгууллагуудын үйл ажиллагааны горимын ялгаа, БОНМС-ийн хөгжлийн төлөв байдлыг илүүтэй таньж мэдэх, зохицуулалт хийхийн тулд СЗ нь БОНМС-ийг хэрэгжүүлэхээс өмнө түүнийг хянуулахаар нэгдсэн БОНМС-ийн тухай танилцуулга хийнэ. СЗ-тай тус тусад нь уулзалт хийж, БОНМС СЗ-дын нэгдсэн/корпорацийн журамд хэрхэн үр дүнтэй нэвтэрч байгааг танилцуулах зорилгоор СЗ нь ТХХТЗ-ийн болон АХБ-ны байгаль орчин, нийгмийн асуудлын ажилтнуудад танилцуулга хийх ёстой. Танилцуулгыг СЗ-ийн байгаль орчин, нийгмийн асуудлыг хариуцсан ажилтнууд хийх нь хамгийн тохиромжтой байх болно. БНХХААБС-д ирүүлж буй хөрөнгө оруулалтын бүх хүсэлтийг нягтлан үзэх үүрэг бүхий СЗ-ийн санхүүгийн үндсэн ажилтан (ажилтнууд) мөн оролцох ёстой.

47. БОНМС-ийг иж бүрнээр танилцуулах бөгөөд үүнд шинэ буюу шинэчилсэн бодлого, иж бүрэн журам, зээл/хөрөнгө оруулалтын хяналтын журамд хэрхэн нийцэж байгаа, байгаль орчин, нийгмийн ажилтнуудын үүргийг хамруулсан СЗ-ийн зохион байгуулалтын схем, БОНМС-ийг нэвтрүүлэхэд зориулсан жилийн төсвийн хуваарилалтыг тус тус багтаана. БОНМС-ийг амжилттай хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавьдаг ажилтнуудын зүгээс тавигдах асуулт, тодруулгад хариулах замаар нарийвчилсан тохируулга хийх боломж олгодог тул ингэж танилцуулга хийх нь БОНМС-ийг нэвтрүүлэх ажлын нэг чухал алхам болох ёстой.

3. БОНМС-ийн эхний алхамууд ба дуусгавар болгох

48. Өмчийн хөрөнгө оруулалтын эхний төлбөрийг олгохоос доод тал нь 3 сарын өмнө СЗ бүр БОНМС-ийн хэрэгжилтэд хяналт тавих чадвартай, ажилдаа үнэнч, мэргэшсэн байгаль орчны болон нийгмийн ажилтнууд ажиллаж байгаа буюу ажилд авах гэж байгаа тухайгаа баталгаажуулна. Эдгээр ажилтнууд нь СЗ-ийн санхүүгийн ажилтнуудтай шууд хамтран ажиллаж үйл ажиллагааг нь чиглүүлэх бөгөөд БОНМС-ийн хэрэгжилтийг дотооддоо тогтмол шалгаж мөн сургалтанд хамрагдана. Мөн СЗ-аас ТУН-д явуулдаг БОНМС-ийн явцын тайланг боловсруулж бэлтгэнэ. СЗ-ийн үйл ажиллагаанд БОНМС-ийг нэвтрүүлэх ажлыг эцэслэн дуусгахын тулд СЗ-ийн байгаль орчин, нийгмийн ажилтнууд нь мөн ТХХТЗБ-ийн байгаль орчин, нийгмийн зөвлөхүүдтэй хамтран ажиллана.

49. БНХХААБС-д өмчийн хөрөнгө оруулалт хийх талаархи анхны хүсэлтийг хүлээн авмагц СЗ-ийн асуудлыг хариуцсан ажилтан хамгааллын шинжилгээний ажиллагааг эхлүүлнэ. Өмчийн хөрөнгө оруулалтын мэдүүлгийн магадлан шинжилгээ, магадлан шинжилгээ, төсөлд ангилал тогтоох ажлыг төслийн талбай дээр биечлэн очиж үзэхдээ нэгтгэж болно. Шаардлага хангасан хөрөнгө оруулагч нь шаардлагатай үнэлгээг хийж дууссаны дараа нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон бусад холбогдох бусад арга хэмжээг гэрээний нөхцлийн дагуу боловсруулах ба Хамгааллын баталгааны бичиг (ХББ)-т гарын үсэг зурна. СЗ нь хэрэгжиж буй хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалтын дотоод хяналтын хүрээнд нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд зохих ёсоор бүрэн дүүрэн хийгдсэн эсэхийг үүний өмнө шалгалт хийсэн санхүүгийн ажилтан (ажлын нийцлийг хангах

зорилгоор) нягтлан үзэх нь зүйтэй.

50. Хэрэв төслийн шийдлийг дахин хянаж үзэж боловсруулах шаардлагатай бол СЗ-ийн санхүүгийн ажилтан шаардлага хангасан хөрөнгө оруулагчтай уулзаж ярилцах ба дахин төлөвлөлтийг удирдаж чиглэлүүлэхийн тулд шаардлагатай бол СЗ-ийн байгаль орчин, нийгмийн ажилтнууд, бусад техникийн ажилтнууд (тухайлбал ХАА-н өртгийн сүлжээний мэргэжилтэн) болон ТУН-тэй зөвлөлдөж ажиллана. Дахин төлөвлөлт хийсний дараа БОНМС-ийн журмын дагуу хүсэлтийг өмнөх шигээ шат шатаар авч үзэх болно.

51. Төслийг хэрэгжүүлэх явцад СЗ нь БОНМС-ийг гүйцэтгэх чиглэлээр ТХХТЗ-ийн байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүдээс техникийн дэмжлэг авах ба ерөнхий хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэхэд ТУН ба АХБ-аас дэмжлэг авна. БНХХААБС-ийн хамгийн их ашиглалтын хугацаа нь ойролцоогоор 10 жил гэж үзэж байна. АХБ-ны санхүүжилттэй АСХХОХ хэрэгжиж дууссаны дараа БНХХААБС-г үргэлжлүүлэн ажиллуулах боломжтой. Гэхдээ БНХХААБС-ийн ийм цаашдын үе шат АХБ-ны удирдамж эсвэл техникийн болон санхүүгийн дэмжлэгт хамрагдахгүй байж магадгүй. Одоогийн байдлаар төслийн дараа СЗ нь БОНМС-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ гэсэн баталгаатай механизм байхгүй байна. БОНМС-ийн амжилтыг төслийг хэрэгжүүлэх явцад Засгийн газар, СЗ, АХБ үнэлэх ба АХБ-ны төслийн гүйцэтгэлийн тайлан (төсөл дууссанаас хойш нэг жилийн дараа) болон цаашдын менежментийн талаарх зөвлөмж үүнд мөн хамааралтай байх болно.

V. ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ

A. Гомдол барагдуулах механизм (ГБМ)

52. СЗ-ийн баталсан төслийн хөрөнгө оруулалтын нийгэм, байгаль орчин, аюулгүй гүйцэтгэлийн талаарх бүх гомдол гаргагчийн гаргасан асуудал, санал, гомдлыг БНХХААБС-д хүлээн авч, үнэлж, шийдвэрлүүлэх зорилгоор БОНБУ-ний зориулалтаар боловсруулсан байсан төслийн онцлог бүхий Гомдол барагдуулах механизм (ГБМ)-ыг АСХХОХ-ийн СЗЗ-ийн бүрэлдэхүүн хэсэгт тохируулан өөрчилнө. бий болгоно. ГБМ нь (зураг 2) орон нутгийн иргэд болон төслийн барилгын ажилд ажиллаж байгаа ажиллагсдын нийгэм, байгаль орчин, аюулгүй байдлын анхаарах асуудлыг илэрхийлж, шийдвэрлэх хурдан шуурхай, ил тод механизм юм

53. Төсөлд хамрагдаж буй бүх байгууллагууд болон нөлөөлөлд өртөж буй талууд ГБМ-ын тухай болон төслийн талаар гарч буй аливаа санал, гомдлыг СЗ-дад хэрхэн мэдээлэх тухай мэдэж байх ёстой. ТУН-ийн болон СЗ-дын байгаль орчин, нийгмийн асуудлын ажилтнууд нь ГБМ-ыг хэрэгжүүлэх гол зохицуулагчид байх болно. Төслийн бусад бүх холбогдох ажилтнууд ГБМ-ын талаар мэдлэгтэй байж, шаардлагатай тохиолдолд дээрх ажилтнуудыг идэвхтэй дэмжиж тусалдаг байх нь зүйтэй.

54. ТУН-ийн байгаль орчны болон нийгмийн ажилтан нь СЗ-ийн байгаль орчин, нийгмийн ажилтнуудаас ирэх мэдээллийг нэгтгэсэн ГБМ-ын хяналт, баримтжуулалтын нэгдсэн тогтолцоог бий болгож эдгээр ажилтнуудтай өдөр тумын ажлаа уялдуулан зохицуулж ажиллана. УБ дахь СЗ-ийн ажилтнууд нь аймгийн төслийн нэгж дэх ажилтнуудтай уялдаатай ажиллаж, уулзалт зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд аймаг, сумын төвийн төслийн талбайд очиж танилцах, төслийн ГБМ-ын нэгдсэн мэдээллийн сантай болох, ГБМ-ын эмхэтгэн хураангуйлсан тайлан бэлтгэж, ТУН-аас АХБ руу явуулах БОХТ-нд тусгуулах үүрэгтэй байна. СЗ тус бүрийн байгаль орчин, нийгмийн ажилтнууд нь батлагдсан төслүүдийн менежерүүд, гүйцэтгэгч компаниуд болон барилгын

хяналтын компаниудад ГБМ-ын журмын талаар зааварчилга өгөх ба шаардлагатай тохиолдолд аймгийн төслийн нэгж дэх хамтран ажиллагсдаас дэмжлэг авна.

55. СЗ-ийн ажилтнууд нь аймгийн төслийн нэгж дэх СЗ-ийн ажилтнуудын дэмжлэгтэйгээр ГБМ-ыг ТУН-тэй хамтарч хэрэгжүүлнэ. Аймгийн төслийн нэгжийн ажилтнууд нь тухайн нэгжийнхээ ГБМ-ын мэдээллийн санг ажиллуулж, мэдээллийг УБ дахь ТУН рүү тогтмол явуулна. ТУН нь УБ хот дахь СЗ-ийн ажилтнуудын оролцоотойгоор жилийн БОХТ бэлтгэж, ГБМ-ын явцын талаар тусгаж, АХБ руу явуулна.

56. Аймаг дахь төслийн нэгжийн СЗ-ийн ажилтнууд нь ГБМ-ын хувьд анх холбоо барих цэг болж ажиллах ба төслийн нийгмийн болон хүрээлэн буй орчинтой холбоотой аливаа гомдол саналыг шийдвэрлэх ажлыг орон нутагт хэрэгжүүлнэ. Аймгийн төвүүд дэх СЗ-ийн ажилтнууд ГБМ-ыг сумдын түвшинд яг ижил байдлаар хэрэгжүүлэх үүрэгтэй. ГБМ нь жендерийн баримжаатай, соёл уламжлалын хувьд зохистой, бүх оролцогч талуудад хүртээмжтэй бөгөөд аливаа дарамт залхаалтаас ангид, үнэ төлбөргүй, ойлгомжтой, ил тод үйл явцыг ашиглан нөлөөлөлд өртсөн этгээдүүдийн асуудлыг шуурхай шийдвэрлэнэ. ГБМ нь үндэсний хууль эрх зүйн тогтолцоонд хандах эрхэд садаа болохгүй.

57. Батлагдсан хөрөнгө оруулалтын төслийн БОТБҮ-г олон нийтээр хэлэлцүүлэх явцад төслийн нөлөөлөлд өртсөн олон нийтэд ГБМ-ын тухай танилцуулна. Танилцуулгыг СЗ-ийн байгаль орчин, нийгмийн хамгааллын ажилтан гүйцэтгэнэ. Батлагдсан төслийн бүх оролцогч талуудад зориулж ГБМ-ыг нийтэд хүртээмжтэй, нээлттэй болгоно.

58. Гомдол үүссэн тохиолдолд СЗ-ийн ажилтнууд ТУН-ийн оролцоотойгоор уг гомдлыг ГБМ-ын дагуу шийдвэрлэхэд нийцэх эсэхийг тодорхойлно. Төсөлтэй холбогдсон бөгөөд БОНМС-ийн хамрах хүрээнд (т: авлига, луйвар зэрэгт хамааралгүй) байх гомдлыг хүлээж авах бөгөөд үүнд нийцсэн гомдлыг аймаг, сумын төвөөс эхэлж дараах байдлаар гурван үе шаттайгаар шийдвэрлэнэ.

- (i) Эхний шат (7 хоногоос хэтрэхгүй): Барилгын ажлын өмнө эсвэл явцад санал гомдол гарсан бол гомдол гаргагч нь асуудлыг гэрээт гүйцэтгэгч, ТХН-ийн ГБМ-ын ажилтнууд, төсөл хэрэгжүүлэх, хяналт тавихад зөвлөх (ТХХТЗ) эсвэл олон нийтийн төлөөлөгчид хандан тавьж болно. ГБМ-ын талаар төсөлд хамрагдах бүх байгууллагууд мэдэж байх ёстой бөгөөд, аливаа санал гомдлыг ТХН-ийн ГБМ-ын ажилтнуудад нэн даруй мэдээлэх хэрэгтэй. Хэрэв уг асуудал нөлөөлөлд өртсөн иргэн болон гүйцэтгэгчийн хооронд шууд шийдвэрлэгдсэн бол гомдлын дагуу нэмэлт арга хэмжээ авах шаардлагагүй. Гэхдээ энэ тухай аймаг/сумын төв дэх ТХН дээр байх ГБМ-ын бүртгэлд бичиж тэмдэглэнэ.
- (ii) 2-р шат (15 хоногоос хэтрэхгүй): Хэрэв асуудал аймгийн төслийн нэгж болон СЗ-ийн ажилтны түвшинд шийдэгдээгүй бол СЗ, ТУН болон БНХХААБС-ТХН руу БХБЯ, ГЗБГЗЗГ, ХХААХҮЯ оролцож ажиллах Нэг цэгийн үйлчилгээгээр дамжин автоматаар шилжинэ. ТУН, СЗ-ийн нэг цэгийн үйлчилгээ болон ГЗБГЗЗГ эсвэл ХХААХҮЯ-ны аль хамаарах нь 2 долоо хоногийн дотор хариуг өгч, болсон бүх үйл явцын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөнө.
- (iii) 3-р шат (15 хоногоос хэтрэхгүй): Асуудал шийдэгдээгүй хэвээр байгаа бол ТУН ба Улаанбаатар дахь СЗ нь шийдэлд хүрэх зорилгоор гомдол гаргагчийн зөвшөөрөлтэйгээр БХБЯ болон холбогдох олон нийтийн төлөөллийг оролцуулсан уулзалт зохион байгуулна. Хэрэв асуудлыг огт шийдвэрлэж

чадахгүй бол холбогдох дээд шатны байгууллагад шилжүүлнэ. БХБЯ нь ТУН болон СЗ-ийн Улаанбаатар дах албаны дэмжлэгтэйгээр тухайн үйл явцыг 1-3 хүртэлх аль нэг шатанд байхад нь АХБ-д мэдээлж болох боловч 3-р шатанд хүрсэн тохиолдолд нэн даруй мэдээлэх ёстой.


Хэрэв i-iii шатуудад асуудлыг шийдвэрлэж чадаагүй бол АХБ-ны Төслийн тусгайлсан зохицуулалтын алба, Гомдлыг хянах хороо руу шийдвэрлүүлэхээр хандана.

59. *Олон нийт* - Олон нийтэд чиглэсэн мэдээлэл түгээх, сурталчлах өргөн хүрээтэй арга хэмжээ авах замаар гомдол барагдуулах механизмын талаар олон нийтийн дунд ойлголт өгнө. ТУН-ийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд болон олон нийтийн хөгжлийн зөвлөхүүд олон нийтийг хамарсан кампанит ажил зохион байгуулж, ядуу, эмзэг өрхүүдэд гомдол барагдуулах журам, эрх үүргийн талаар мэдээлэл өгч, тэднийг гомдол, саналыг барагдуулж байхын тулд ТУН, СЗ, төсөл хэрэгжүүлэх, хяналт тавих зөвлөхүүдтэй хамтран ажиллана.

60. *Гомдол гаргагч* (ГГ) нь гомдол/санал барагдуулах саналын маягтыг БХБЯ-ны Иргэдэд үйлчлэх нэг цэгийн албанд өгөх, барилгын бүх талбайд байрлуулах төлбөргүй утсаар мэдээлэх, цахим болон энгийн шуудангаар илгээх, бичгээр үйлдэж иргэдэд үйлчлэх төвийн өргөдөл гомдлын системд бүртгүүлэх зэргээр гомдол/саналаа уламжлах олон төрлийн уян хатан боломжоор хангагдана.

61. Барилгын ажлын үе шатанд хүмүүс санал, асуудлуудаа бичгээр хүргүүлэхдээ ашиглах цаг уурын нөлөөнөөс хамгаалагдсан *санал гомдлын хайрцгуудыг* барилгын талбай, нийгмийн үйлчилгээний одоогийн барилга байгууламжууд, багийн байранд байрлуулна. Бүх санал гомдлын хайрцгийг дагалдуулан СЗ-ийн нийгэм, байгаль орчны ажилтнууд, орон нутгийн зохицуулагч, орон нутгийн төсөл хэрэгжүүлэх нэгж болон Улаанбаатар дах ТУН, СЗ-ийн байгаль орчи, нийгмийн ажилтнуудын шинэчилсэн мэдээллийг байлгана. Мөн харилцах үйл явцын нөхцлийг бүрдүүлж, энгийн маягт болон үзэг, бал тавьсан байна.

Зураг 2. Гомдол барагдуулах механизм¹²



БХБЯ – Барилга, хот байгуулалтын яам, ГЗБГЗЗГ – Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, СЗ – Санхүүгийн зуучлагч

1. Бүртгэл хөтлөх

62. Бүх санал, гомдлын бүрэн баримтжуулалт, үүнд гомдол гаргагчийн нэр, гомдлыг хүлээж авсан өдөр, гомдол гаргагчтай холбоо барих хаяг, асуудалтай байгаа газрын байршил, асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн эсвэл шийдвэрлэх тухай мэдээллийг бүртгэж, хадгална. Аймаг, сумын төслийн нэгж дэхь СЗ-ийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтан ба УБ дахь СЗ-дын хамтран ажиллагчид нь байгаль орчин, нийгмийн хамгааллын талаар гаргасан гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэх, энэ талаар ТУН-ийг тогтмол мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.

63. Бүртгэгдсэн болон шийдвэрлэгдсэн өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлтийн үр дүнг аймаг дахь төслийн офис болон ТУН – БХБЯ/ГЗБГЗЗГ, ХХААХҮЯ-д дэлгэж мэдээлэхийн

¹² АСХХОХ-ийн I шатлалд зориулан бэлтгэсэн ГБМ-аас авсан.

зэрэгцээ байгууллагуудын цахим хуудсанд байршуулна. Мөн АХБ-нд жил тутам хүргүүлэх БОХТ-нд тусгана.

2. Ээлжит хяналт хийх ба авсан сургамжийг баримтжуулах

